ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЕТТ

ЭРДЭНЭС СЭТГҮҮЛ

2020.04.08 | №01

Дэлхийн жишиг уурхай Эрдэнэс-Тавантолгой





ISO 45001:2018



ISO 9001:2015



ISO 14001:2015

"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХУВЬЦААТ КОМПАНИ

ТАЙЛАН 2019



www.ett.mn

ТАЙЛАН СЭТГҮҮЛ БЭЛТГЭСЭН

Захиргаа, удирдлагын хэлтэс
Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах хэлтэс

АГУУЛГА

01 КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

- Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ
- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- Ярилцлага
- Компанийн товч танилцуулга

02 КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2019 оны онцлох амжилт
- Компанийн засаглал, удирдлага
- Нүүс олборлолт, геологи хайгуул
- Нүүрс борлуулалт
- Тээвэр, логистикийн үйл ажиллагаа
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- Байгаль орчин, усны бодлого, нөхөн сэргээлт
- Эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаа
- Захиргаа, хүний нөөц
- 1072 хувьцааны мэдээлэл

03 ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

- Тавантолгойн уурхайн хөгжил
- Нүүрс баяжуулах үйлдвэр
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам
- Тавантолгой Түлш ХХК

04 ГАДААД ХАРИЛЦАА, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

- Гадаад харилцаа
- Орон нутаг, хамтын ажиллагаа
- Нийгмийн хариуцлага



МЭНДЧИЛГЭЭ

Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр Тавантолгойн нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг 10 жилийн тэртээ байгуулсан цагаас тус компани нь улс орны эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмрээ оруулж ирсэн бөгөөд ялангуяа 2019 онд компанийн удирдлагын зүгээс менежментийн оновчтой бодлого авч хэрэгжүүлсний үр дүнд компанийн засаглалыг сайжруулах, нүүрс олборлолт, борлуулалтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх үүргээ нэр төртэй биелүүлэн нэг тэрбум ам.долларын борлуулалтын орлоготой төрийн өмчийн оролцоот компани болсон байна.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2019 онд төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 7 гишүүн, хараат бус 4 гишүүн, нийт 11 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 27 удаа зохион байгуулан 91 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 67 тогтоол гаргасан байна.

Компанийн засаглалыг сайжруулах хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлөөс “Ногдол ашгийн бодлого”, “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам”, “Компанийн засаглалын кодекс”, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”, Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын ажиллах журам (Цалин урамшууллын хорооны журам, Нэр дэвшүүлэх хорооны журам, Аудитын хорооны журам, Хөгжил, төлөвлөлтийн түр хорооны журам), Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам, “Дотоодын болон гадаадын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалахтай холбоотой зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам” зэрэг эрх зүйн баримт бичгүүд, стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулан батлаж мөрдөн ажиллажээ.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь 2019 онд Цанхийн Зүүн болон Баруун уурхайд олборлолтын үйл ажиллагааг явуулж, **18** сая тонн нүүрс олборлон, **14.95** сая тонн нүүрс борлуулж, **2.1** их наяд төгрөгийн орлого олж, улсын төсөвт **522.3** тэрбум төгрөгийн татвар хураамж төвлөрүүлэн **728.7** тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөж, төсвийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан.

2019 оны гүйцэтгэлээр **16.2** сая тонн нүүрс олборлож **15.5** сая тонн нүүрс борлуулан, **2** их наяд **660** тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, өмнөх оноос нүүрсний борлуулалтын орлого **34** хувиар, борлуулалтын хэмжээ **18** хувиар нэмэгдсэний үр дүнд **1** их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Тус компани 2019 онд үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлж “Эрдэнэс-Тавантолгой Майнинг” ХХК, “Тавантолгой төмөр зам” ХХК зэрэг охин компанийг байгуулан, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд болон нийгмийн хариуцлагын хүрээнд “Тавантолгой Түлш” ХХК-д шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтыг үе шаттайгаар шийдвэрлэж ажилласан болно. Мөн компанийн 2019 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 90 төгрөгийн ногдол ашгийг иргэд, хуулийн этгээдийн эзэмшиж буй хувьцаанд мөнгөн хөрөнгөөр, төрийн өмчийн нийт хувьцаанд компанийн эзэмшиж байгаа үнэт цаасаар хуваарилахаар Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэлээ.

Цаашид нүүрсний салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах, байгаль орчин, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, Өмнийн говийн бүсийн тогтвортой хөгжил, дэд бүтцийн их бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилтуудыг компанийн засаглалыг сайжруулах замаар хэрэгжүүлэхийн төлөө компанийн удирдлага, хамт олныг чиглүүлэн хариуцлагатай, идэвх зүтгэл, санаачилгатай ажиллах болно.

Хөгжлийн зөв хандлага руу орох үндэс суурь нь тавигдсан компани маань цаашид олон улсын нүүрсний зах зээлд өрсөлдөх чадвартай, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг бүрэн дүүрэн хангасан нийгмийн хариуцлага бүхий олон улсын томоохон компани болно гэдэгт Төлөөлөн удирдах зөвлөл бүрэн итгэлтэй байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

“Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага Монголын төр болон хувьцаа эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, төмөр зам, дэд бүтцийн төслүүдээ санхүүжүүлж, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх зорилтуудыг бүрэн хангаж, компанийг өндөр үр ашигтай ажиллуулж, хувьцаанд ногдох ногдол ашгийг олгох боломжийг эхлүүлсэн амжилттайгаар Хувьцаа эзэмшигчдийн хурлыг угтлаа.

Манай компанийн удирдлага, ажилтан, уурхайчдын хичээл зүтгэл, нөр их хөдөлмөрийн үр дүнгээр 2019 онд “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компани **60 сая** дахь тонн нүүрс олборлож, **1 тэрбум** ам.долларын борлуулалтын орлоготой ажиллаж, **1 их наяд** төгрөгийн цэвэр ашигтай ажилласан үзүүлэлт нь Монгол улсдаа анхдагч болон бүртгэгдэж, 2019 оны “Шилдэг менежмент”-тэй компани, хамт олон болж, бусад аж ахуйн нэгжүүдийг олон үзүүлэлтээр тэргүүлснийг дуулгахад таатай байна.

Түүнчлэн компани урт хугацааны хөгжлийн стратеги, бодлогоо боловсруулан хэлэлцүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын томоохон төслүүдийг санхүүжүүлж, 100 хувийн хөрөнгө оруулалттай “Эрдэнэс-Тавантолгой Майнинг” ХХК байгуулав.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор “Тавантолгой түлш” ХХК-ийг байгуулж **111.8 тэрбум** төгрөгийн санхүүжилт олгосноор Улаанбаатар хотын утааг **55** хувь бууруулж чадсан нь бидний амжилт юм.

Компани дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй хамтран сайн чанарын нүүрс угаан баяжуулж, нэмүү өртөг шингэсэн анхны бүтээгдэхүүнээ 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн экспортолж эхэллээ. Дээрх хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хийсний үр дүнд их бүтээн байгуулалтууд өрнөж 7000 гаруй ажлын байр бий болгоод байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-иас санаачлан “Хуримтлалтай Хувьцаатай иргэн” аяныг **21** аймаг, **330** суманд амжилттай зохион байгуулж 604 удаагийн уулзалт, сургалтаар **40,864** иргэнийг хамруулсан байна. Мөн төрийн албан хаагчдын **301** удаагийн сургалтыг зохион байгуулж **6406** албан хаагчийг хамруулж, **33130** иргэнээс дэлгэрэнгүй судалгаа авсан ба нийт **15000** гаруй иргэний хувьцааны анхан шатны баримтыг цахимжуулсан нь компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдэдээ хүрч ажиллах чухал арга хэмжээ боллоо.

Компани 2016 оноос эхлэн алдагдалгүй ажиллаж, 2017, 2018 онуудын цэвэр ашиг, орлогоор гадаад, дотоод бүхий л өр төлбөрийг бүрэн төлж барагдуулснаар 2019 онд өндөр үр ашигтай буюу 1 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллах суурь боломжийг бүрдүүлж, хувьцаа эзэмшигч төрд болон **2.5 сая** иргэн, **468** аж ахуйн нэгж бүрт ногдол ашиг олгох шийдвэрийг гаргасан.

2020 онд бид компанийн үйл ажиллагааг олон улсын стандарт нийцүүлэх, засаглалын нээлттэй байдлыг бий болгох, уурхайд орчин үеийн ажлын байр, ажилчдын хотхоныг барьж, өөрсдийн олборлолтийн техник, тоног төхөөрөмжтэй болох, нүүрс баяжуулах болон кокс, химийн үйлдвэртэй болох судалгаа, зураг төслийг бүрэн дуусгаж, ажлыг эхлүүлэн, логистикийн төв, төмөр зам, авто замын бүтээн байгуулалтын ажлуудаа урагшлуулж, шинээр байгуулагдах Эрдэнэсийн хот байгуулагдах суурийг тавих зэргээр өмнөх жилүүдэд гаргасан амжилтаа улам ахиулахаар хичээн зүтгэж байна.

Та бүхний цаашдын ажилд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Дэлхийн жишиг уул уурхай–“Эрдэнэс-Тавантолгой”

“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ГАНХУЯГ

ЯРИЛЦЛАГА

“Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал

БАТТУЛГЫН ГАНХУЯГ



КОМПАНИ АНХ УДАА НЭГ ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГОТОЙ АЖИЛЛАСАН

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуягтай цаг үеийн асуудлаар ярилцлаа.

-Танд энэ өдрийн мэнд хүргэе! Танай компани төрийн өмчит компаниудаас анх удаа нэг тэрбум ам.долларын борлуулалтын орлоготой ажилласан амжилттайгаар 2020 оныг угтжээ. Өнгөрсөн оны амжилтаасаа хуваалцахгүй юу?

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хамт олон 2019 онд нэг тэрбум ам.долларын борлуулалтын орлоготой ажиллан төрийн өмчит компаниудаас Монголдоо анхдагч болсон нь бидний ажлын томоохон үзүүлэлтийн нэг болоод байна. Өнгөрсөн онд манай компани 15.5 сая тонн нүүрс борлуулж, улсад 736 тэрбум төгрөгийн татвар хураамж төвлөрүүлэн, нэг их наяд гучин таван тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа. 77 сая метр куб уулын цулын ажил хийж гүйцэтгэсэн нь 2018 оны энэ үетэй харьцуулахад уулын цул 134 хувиар илүү бүтээлтэй ажилласан үзүүлэлт болсон.

Манай компанийн хувьд 2017 онд 461 тэрбум, 2018 онд 807 тэрбум, 2019 онд нэг их наяд гучин таван тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаад байна.

Тавантолгой-Зүүнбаянгийн төмөр замын ажлыг өнгөрсөн онд эхлүүлснээс гадна олон жил гацаад байсан Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын ажлын санхүүжилтийг хариуцан гүйцэтгэж байна. 2019 онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажилд зориулан 357 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийсэн бол Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замд 308.8 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдээд байна. Эдгээр төслүүдийг “Тавантолгойн ордоос Сайншанд, Чойбалсан хотыг холбосон төмөр замын бүтээн байгуулалт нь шинэ хэд хэдэн гарцууд бий болохоос гадна, эдийн засгийн хувьд нэмүү өртөг шингэх, компанийн өртөг зардал буурах өндөр үр ашигтай төслүүд гэж судлаачид үздэг.

Мөн ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, ISO 14001:2015 Байгаль орчны

менежментийн тоглолцоог нэвтрүүлсэн анхны Монгол компани болон бүртгэгдсэн гээд өнгөрсөн жилийн онцлох ажлуудаас товч дурдахад ийм байна.

Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд "Хуримтлалтай Хувьцаатай иргэн" аяныг 2019 оны 10-11 дүгээр сард 21 аймаг, 330 суманд амжилттай зохион байгуулав. Аяны хугацаанд нийт 1000 удаагийн сургалтаар 46 мянга гаруй иргэнд мэдээлэл зөвлөгөө өгөн ажиллалаа.

- Чалко болон Хөгжлийн банкны өрийг бүрэн төлж барагдуулсан гэсэн? Нийт хэдэн төгрөгийн өр төлсөн бэ?

-Тийм. Бүх өрийг хүүтэй нь тооцохоор 1.3 их наяд төгрөгийн өрийг компани, манай уурхайчид нуруун дээрээ үүрж, төлж барагдуулсан. 2017 оны гуравдугаар сарын 31-нд Чалко компанийн өрийг тэглэж, 2018 оны 10 дугаар сарын 24-нд Хөгжлийн банкны өрийг дарж, түүнээс хойш компани дотоод, гадаад ямар ч өргүй болсон.

-"Тэг" хувийн ашигтай компанийг ингэж ашигтай болгож ажиллахад компанийн удирдлагууд ямар менежмент хийсэн бэ?

Биднийг 2016 онд эргэн ирж, ажлаа авах үед нүүрсний үнэ дөнгөж өндийх зэрэг үзүүлэлт гарсан ч манай компани маш их хэмжээний өртэй байсан. Мөн компани үрэлгэн зардлууд маш ихтэй болсон, тэр нь жилээс жилд өссөн үзүүлэлттэй байлаа. Чалко болон Хөгжлийн банкны их өрийг дарж чадах уу, эс чадах уу гэдэг асуудалтай тулгарчихсан байлаа. Их хэмжээний өртэй учраас лицензийг нь зарж, хувьд шилжүүлье гэдэг асуудал УИХ-ын түвшинд хүртэл яригдаж байсан удаатай. Тухайн үед компанид зөвхөн 34 хувийг нь үлдээж, бусад хувийг нь хувийн хэвшилд өгөх бодлого ч яригдаж байсныг нуугаад яах вэ.

Ер нь манай уурхайчид компаниа гэсэн сэтгэл, эр зориг гаргасны хүчинд Монголчууддаа авч үлдсэн гэж ойлгож болно. Ингээд 2018 оны эцэс гэхэд гадаад, дотоод ямар ч өргүй болж, "Эрдэнэс Тавантолгой" ХКомпани 2019 оны цэвэр ашиг нь ч өндөр гарч, одоо төрд, иргэддээ ногдол ашиг өгөх хэмжээнд хүрсэн цэвэр бизнесийн зарчмаар ажилладаг байгууллага болсон.

Үүнд энэ Засгийн газрын бодлого, шийдвэр ч нилээд сайн нөлөөлсөн. Засгийн газраас "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагаанд улс төрчдийг оролцохыг хатуу хориглосон. Мөн дуртай үедээ компаниас татаас авдаг байдлыг халсан. Учир нь 2014 онд Хөгжлийн банкнаас зээлээр авсан мөнгөнөөс төр татварын урьдчилгаа гээд олон тэрбум төгрөгийг татаас хэлбэрээр авч байсан байна лээ. Өөрөөр хэлбэл, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийг улс татвар, бизнестээ дур зоргоороо ашигладаг байсан гэсэн үг. Харин одоогийн Засгийн газар зөвхөн бизнесийн зарчмаар ажиллах боломжийг нь нээж өгсөн. Ингэснээр баланс нь цэвэр болж, бизнесийн хууль үйлчилдэг болж, бусад томоохон аж ахуйн нэгжүүдтэй өрсөлдөх хэмжээнд хүрч, хөрөнгө оруулагчид сонирхох болж, гадаад зах зээлээс их хэмжээний хөрөнгө босгох чадавх бүхий компани болоод байна даа.

> Бүх өрийг хүүтэй нь тооцохоор 1.3 их наяд төгрөгийн өрийг компани, манай уурхайчид нуруун дээрээ үүрж, төлж барагдуулсан. 2017 оны гуравдугаар сарын 31-нд Чалко компанийн өрийг тэглэж, 2018 оны 10 сарын 24-нд Хөгжлийн банкны өрийг дарж, түүнээс хойш компани дотоод, гадаад ямар ч өргүй болсон

-Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барих хөрөнгийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас гаргасан. Бусад төсөл хөтөлбөрүүдийн тухайд мэдээлэл өгөхгүй юу?

-Төмөр замын хувьд анхан болон дунд хугацааны хөрөнгө оруулалтууд манайхаас гарсан байгаа. Бид тэрбум доллараар том төслүүдээ санхүүжүүлж байна. Ерөнхийдөө Тавантолгойн төслийг цогцоор аж үйлдвэрлэлийн паркын хэмжээнд төлөвлөсний дагуу бүрэн хөгжүүлэхэд 3.7 тэрбум доллар шаардлагатай байгаа юм.

Тухайлбал, Нойтон аргаар угаах нүүрс баяжуулах 30 сая тонныг үйлдвэр, Хуурай баяжуулах 5 сая тонныг үйлдвэр, Коксын үйлдэр, Химийн технологийн үйлдвэр барих, хөрөнгө оруулалт нь хийгдээд эхэлсэн төмөр замуудын үлдэгдэл санхүүжилт, мөн автозам эдгээр замыг дагасан суурьшлын бүс, үйлчилгээ, дэд бүтэц зэрэг асуудлыг шийдсэн 100 мянган хүн амтай хотыг Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байгуулах гээд томоохон зорилтуудад зарцуулах юм. Одоогоор төслүүдийн анхны хөрөнгө оруулалтыг компани бие даагаад хариуцаад явж байна.

-Энэ ажлыг үргэлжлүүлэхийн тулд "Тавантолгой төмөр зам" гэдэг компани байгуулагдаад байгаа. Танайх хэдэн хувийг нь эзэмшдэг вэ. Компанийн ажиллах хүч 100 хувь дотоодоос гэж сонссон юм байна?

-34 хувийг "Монголын Төмөр зам" компани, 66 хувийг нь "Эрдэнэс-Тавантолгой" ХК эзэмшиж байна. Ажил одоо дөнгөж эхлэж байна. 2019 оны наймдугаар сард тогтоол, шийдвэр нь гарсан. Өвлийн улиралд хийх боломжтой ажлууд нь явагдаж байгаа.

Ажиллах хүчний хувьд дотоодын ажилчид байгаа. Гэхдээ мэргэжлийн зөвлөхүүд нь гадны мэргэжилтнүүд юм. Төлөвлөсний дагуу хурдан бөгөөд чанартай, стандартын дагуу барих нь чухал гэдэг зарчмаар ажиллаж байна. Тавантолгой-Гашуун сухайтын төмөр замыг л гэхэд 28 сарын дотор барьж, ашиглалтад оруулах хатуу үүрэг бүхий гэрээтэй ажиллаж байгаа.

-Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаа хугацааны хувьд нэгэн зэрэг ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байгаа юу?

-Дээрх хоёр чиглэлийн төмөр замыг нэгэн зэрэг ашиглалтад оруулах буюу 26-28 сарын дотор ашиглалтад оруулна гэсэн төр засгийн бодлого, зорилт бий.

-Ингээд төмөр замаар нүүрсээ тээвэрлэдэг болчихлоо гэж үзэхэд эдийн засгийн үр өгөөжийг нь хэрхэн үнэлж байгаа вэ?

-Баруун, Зүүн цанхийн уурхай тус бүр 30 сая тонн, Бортээгийн уурхай 15 сая тонн, нийтдээ 75 сая тонн нүүрс жилд олборлож байж Тавантолгойн уурхайг бүрэн хүчин чадалдаа хүрлээ гэж үзэх юм. Үүний 30 сая тонныг нь нойтон аргаар Тавантолгой ордын бассейн дээрээ боловсруулдаг болно. Харин 5 сая тонныг нь хуурай аргаар боловсруулна гэж үзэж байна. Үлдсэн 40 сая тонн нүүрсний 10-15 саяыг нь БНХАУ болон бусад улсын үйлдвэртэй хамтарч нойтон аргаар угаах замаар ашиглахаар төлөвлөж байгаа юм. Цаашид 20-25 сая тонн нүүрсийг нь Зүүнбаянгийн төмөр замаар тээвэрлэж, угаах үйлдвэр, коксын үйлдвэр, металлургийн үйлдвэр гэсэн гурван том үйлдвэрт боловсруулна.

Өөрөөр хэлбэл, тэнд хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүн боловсруулж, тээвэрлэнэ гэсэн бодлого барьж байгаа. 60 жилдээ ямартай ч 100 мянган хүн амтай хот байгуулна гэсэн стратеги төлөвлөгөө нь батлагдчихсан ажил явж байна.

-Ерөнхийдөө "Эрдэнэс-Тавантолгой" ХК маань ашигтай ажиллаж, иргэд ашиг хүртэх өдөр ойртож байгаа юм байна гэж ойлголоо. Уул уурхайн компаниудын хувьд байгаль орчны нөхөн сэргээлтэд анхаарах нь нэн тэргүүний ажил байдаг. Энэ чиглэлд хийж буй ажил, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал, тоосжилт гэхчлэн заавал ярих ёстой асуудлууд үлдээд байна. Энэ талаар ямар бодлого хэрэгжүүлж ажиллаж байна вэ?

-Та яг зөв асуудлыг хөндөж байна. Хамгийн чухал нь энэ байгаль орчин, тоосжилтын асуудал байна. Манай уурхай маш их тоосжилттой. Тоосжилтыг бууруулах чиглэлээр үр дүнтэй ажиллахын тулд ОХУ, Канадын компаниудын туршлагыг судалж, хамтран ажиллаж байна. Канад, Америкийн уул уурхайн компаниуд усалгааны шингэндээ байгаль орчинд ээлтэй, хүн, амьтан, ургамалд хоргүй нягтаршуулах бодисыг ашигладаг юм билээ. Бид үүнийг нэвтрүүлэх гээд хоёр компанитай хамтран туршилт хийгээд ажиллаж байна. Эхний туршилт маань маш амжилттай болж, тоосжилтыг 70 хувиар бууруулах боломжтойг тогтоосон.

Байгаль орчны чиглэлээр нэлээд ажлууд хийхээр зорьсон. Үүний нэг нь "Ногоон Говь" төсөл юм. Одоогоор 60 мянган мод суулгац говийн хөрсөнд тариад байна. Цаашлаад Цогтцэций суманд ногоон байгууламж барих ажил маань эхлээд байна. Эдгээр ажлын хүрээнд байгаль орчны чиглэлээр ажилтнуудаа сургаж, мэргэшүүлэх шаардлагатай байгаа учраас Байгаль орчин, усны бодлогын хэлтэс байгуулсан. Ийм тодорхой ажил хариуцсан нэгжтэй болсны үр дүнд байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр ажил хийх, иргэд, малчидтай уулзаж, мэдээлэл өгөх ажлууд шат дараатай хийгдэж байна.

Монголын хөрс, ялангуяа говийн хөрсөнд тохирсон ургамал, мод, сөөг тарих ажлыг бид эртнээс л янз бүрийн байдлаар туршиж ирсэн. Туршилтын талбай болон хэд хэдэн ногоон байгууламж бүхий газрууд байгаа. Тэндээс ургамлын дээж, үрсэлгээг авч өөр бусад газруудад тарьж, суулгах зэргээр ажиллаж байна. Хоёр жилийн дараа үр дүн, эерэг өөрчлөлтүүд гарсан байна гэдэгт итгэлтэй байгаа. Манай ажилчид "Говийг ногооруулъя" гээд л зүтгээд байгаа шүү дээ. Энэ ажлын үзүүлэлт болон хөдөлмөр хамгаалал, үйлдвэрлэл, засаглал гэсэн үзүүлэлтээр шалгарч "Эрдэнэс-Тавантолгой" ХК олон улсын нэгдсэн менежментийн ISO 9001:2015, ISO 45001:2018, ISO 14001:2015 стандартын батламжийг 2019 оны аравдугаар сард Францын Парис хотноо очиж гардаж авлаа. ISO 45001:2018 батламжийг авсан Монголын анхны уул уурхайн компани болсон.

-Тоосжилтыг бууруулахад автозамын бүтээн байгуулалт нэлээд нөлөөтэй байх. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр шороо их босдог шүү дээ. Автозам барих чиглэлд ямар ажлууд явагдаж байна вэ?

-Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн замыг параллель болгоно. Өөрөөр хэлбэл, нэг замаар нь ирж, нөгөө замаар нь буцдаг болгоно. Мөн Тавантолгой, Оюутолгой, Хангимандалын чиглэлд зам баригдана. Замын хувьд дан ганц тоосжилт гэхгүй бусад асуудал дагуулдаг. Ганцхан чиглэл буюу автозамаар нүүрс тээвэрлэж байгаа



учраас хүндрэл их гарч, экспорт тасалдах байдал олон гардаг. Тиймээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг яаралтай ашиглалтанд оруулж, түүнээс өмнө ядаж л Ханги-Мандалын боомт чиглэлийн автозам нээгдчихэд л шинэ гарцууд бий болж, экспорт тасалдахаа болино. Ингэснээр компанийн орлого нэмэгдэж, цаашлаад төлөвлөсөн бүтээн байгуулалтын ажлууд хугацаандаа ашиглалтад орох, мөн угаасан, хольсон нүүрс, металлург, эцсийн бүтээгдэхүүн гэсэн нэмэлт хэд хэдэн төрлийн хагас, бүтэн боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж, хилийн 6 хүртэл боомтоор гарах боломжтой болно.

-Тавантолгойн орд газарт байрладаг Цогтцэций сумын Цагаан-Овоо багийг нүүлгэн шилжүүлэх ажил хэзээнээс эхлэх вэ?

-Уул уурхайн тоосжилтод хамгийн их өртөж буй Цогтцэций сумын Цагаан-Овоо баг болон жижиг Тавантолгойн ажилчдын тосгоныг нүүлгэх анхан шатны үнэлгээг хийж, эхний ээлжинд багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх зардлыг 2020 оны төсөвт бүрэн суулгасан. Энэ багийг нүүлгэж байж Баруун цанхийн уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллах боломж бүрдэнэ. Дээр хэлсэнчлэн "Тавантолгой"-н уурхай үндсэн хүчин чадлаараа ажиллаад эхэлбэл жилд 75 сая тонн нүүрс олборлоно шүү дээ. Олон улсын жишгээр бол ил уул уурхайн бүсэд суурьшлын бүс байлгадаггүй. Энэ жишгийг бид дагаж, нүүлгэн шилжүүлэлт хийж, шинэ суурьшлын бүсдээ хөгжүүлэлт хийж, хүн амаа эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл, ажлын байраар хангах ажлуудыг хийнэ. Ингэж байж нөхөн сэргээлтийн ажлууд ч жинхэнэ утгаараа өрнөнө. Дэлхийн жишиг уурхайнууд анх тухайн орон нутаг, газар ямар байсан, ямар ан амьтан идээшилж, ямар төрлийн ургамал ургадаг байсан, яг тэр л унаган төрхөөр нь эргэж нөхөн сэргээж байна. Бид ч бас энэ жишгээс суралцаж, хэрэгжүүлэх бодлого чиглэл баримталж байгаа.

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хувьцаа эзэмшигчиддээ анх удаа ногдол ашиг өгөх шийдвэр гаргалаа. Ногдол ашгийг хэзээ өгөх вэ?

Компанийн хувьд ч, төр болон иргэдийн хувьд ч ногдол ашиг өгөх асуудал бол түүхэн шийдвэр байсан гэдгийг онцолмоор байна. Ямар ч бизнесийн компани нэг төгрөгний ч хамаагүй цэвэр ашигтай ажиллахын төлөө зүтгэж ажиллах зорилго тавьдаг. Ашигтай ажилласан, өр төлбөргүй, дараагийн



төслүүдээ санхүүжүүлэх чадвартай л бол аль ч тохиолдолд хувьцаа эзэмшигчиддээ ашгаасаа ногдол ашиг олгох нь бизнесийн бичигдээгүй хууль байдаг. Энэ үүргээ компани биелүүлж чадсан.

Нөгөө талаар олон жил дараалан яригдсан 1072 хувьцаа хэзээ амь орох вэ гэсэн асуултын хариулт нь 2019 оны ашгаас анх удаа олгож байгаа ногдол ашиг гэдгийг маш сайн ойлгож, хувьцаа эзэмшигч иргэн бүр өөрийгөө бизнесмэн хүн буюу хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвартай хувьцаа эзэмшигч гэдэг талаас нь ойлгож, хүлээн авах хэрэгтэй. Энэ бол таны оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөж, цаашид ч оруулсан компани тань улс төрөөс хараат бус байж, зөвхөн бизнесийн хууль, зарчимаар ажиллах хөгжлийн замдаа орлоо гэж ойлгож болно.

Энэ жил Монголын хувьцаат компаниудаас 22 компани ногдол ашиг олгох шийдвэр гаргаж, нийт 87.8 тэрбум төгрөг олгохоос нэгж хувьцаанд дунджаар 30-60 төгрөг олгох болсон байна. Харин манай нэгж хувьцаанд 90 төгрөг олгохоор болсон нь тийм бага хэмжээ биш гэдгийг онцолмоор байна. Цаашид ч жил бүр өсөх боломжтой төсөл гэдгийг ч олон улсын хөрөнгө оруулагчид дүгнэсээр байгаа.

Монгол улсад хувьцаат компани ногдол ашиг олгодог эрх зүйн зохицуулалт гэж бий. Энэ хүрээнд бүх үйл явц явагдана. Энэ нь санхүүгийн зохицуулах хорооны ногдол ашиг хуваарилах шинэ журмаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 5 дугаар сарын 1-ний өдрөөс хойш энэ ондоо багтан олгох ёстой. Энэ дашрамд хэлэхэд ногдол ашигтай холбоотой бүх мэдээллийг компанийн вэб сайт, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн болон 1072 хувьцаа мэдээллийн төвийн пэйж хуудас, 1800-1072 утас, Эрдэнэс-тавантолгой апликейшнээс авах боломжтой.

Бид хувьцаа эзэмшигчиддээ мэдээ, мэдээлэл хүргэх, хувьцааныхаа тоо ширхэгийг шалгах, хянах, санал хүсэлтээ өгөх боломжтой нэгдсэн бүртгэлийн цогц системийг нэвтрүүлсэн. "Эрдэнэс-Тавантолгой" гэсэн нэртэй аппликэйшнийг татаж авч хэрэглэснээр иргэд хувьцааныхаа тоо ширхэгийг шалгах, мэдээ мэдээлэл авах, санал өгөх зэргээр ашиглаж цаашдаа "Эрдэнэс-Тавантолгой" компанитай хувьцаа эзэмшигчийн зүгээс холбогдох, хөрөнгийн зах зээлд оролцох бүрэн боломжтой болох юм.

Танд баярлалаа.

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА





АЛСЫН ХАРАА

ДЭЛХИЙН ЖИШИГ УУРХАЙ-ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид сайн чанарын нүүрсний “ЕТТ 1, 2, 3, 4” брэнд код бухий бүтээгдэхүүн бий болгож, аюулгүй, тогтвортой, хариуцлагатай уул уурхай, аж үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэлийг хөгжүүлэн, улс орон болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмрээ оруулан, хувьцаа эзэмшигч Монгол Улсын төр, иргэн бүрт ашиг хүртээнэ.



ҮНЭТ ЗҮЙЛС

- Мэргэшсэн өндөр чадавхи, манлайлал
- Нээлттэй, ил тод байдал
- Өндөр чанартай бүтээгдэхүүн
- Тогтвортой хөгжил
- Харилцагч түншлэгч

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГОО
НЭГ ТЭРБУМ АМ.ДОЛЛАРТ
ХҮРГЭСЭН АНХНЫ МОНГОЛ КОМПАНИ

Тавантолгойн нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Улаан нуурын хөндийд, Монгол-Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмодны боомтоос 270 км зайд байрладаг бөгөөд нийт 220 хавтгай дөрвөлжин км талбайг эзэлдэг. Тавантолгойн бүлэг орд нь Цанхи, Бортээг, Ончхараат, Оорцог, Бортолгой, Ухаахудаг гэсэн зургаан талбайгаас бүрдэх бөгөөд одоогийн байдлаар компани Цанхийн хэсэгт олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

Орд нь олон улсын Жорк стандартын ангиллаар

7.4


тэрбум тонн нүүрсний нөөцтэй, үүний

5.1

тэрбум тонн нь коксжих нүүрс бол

2.3

тэрбум тонн эрчим хүчний нүүрс юм.




Тавантолгойн нүүрсний ордын онцлог нь дээд зэрэглэлийн коксжих нүүрсний нөөцтэй ба нүүрсний шинж чанарын хувьд хүхэр болон үнслэгийн агууламж багатай.

НҮҮРСНИЙ ЧАНАР


ОЛБОРЛОЖ БУЙ НҮҮРСНИЙ ЧАНАРЫН МЭДЭЭЛЭЛ

Давхарга	Нийт чийг (ar)	Үнс (db)	Дэгдэмхий бодис (daf)	Хүхэр (db)	Илчлэг (ar)	Чөлөөт хөөлтийн индекс	G-Индекс
	%	%	%	%	Cal/g		5:1
Коксжих нүүрс 3-р давхарга	2.5-4	12.1-16-5	25.3-27.2	0.7-1.3	5500-6500	5-7	70-80
Коксжих нүүрс 4-р давхарга	2.8-3.7	11.7-17.2	27.3-29.5	0.5-0.9	5500-6500	5-8	75-90
Эрчим хүчний нүүрс (Исэлдсэн)	6-9	12-22	25-30	0.4-1.2	5500-6500	0-1	-



ОРДЫН НӨӨЦ (Уламжлалт тооцооллын аргаар)
Газрын гадаргаас 300 м хүртэлх гүнд 3.76 тэрбум, үүнээс коксжих 2.75, эрчим хүчний нөөц 1.01 тэрбум тн,
Газрын гадаргаас 300 м-с доош гүнд 2.55 тэрбум, үүнээс коксжих 578 сая тн, эрчим хүчний нөөц 1.97 тэрбум тн

- 2010 оны наймдугаар сарын 27-ны өдөр Цанхийн зүүн уурхайн олборлолтын үйл ажиллагаа эхэлсэн.
- 2013 оны есдүгээр сарын 05-ны өдөр Цанхийн зүүн уурхайн гүний гааль байгуулагдсан.
- Мөн 2013 оны есдүгээр сард Цанхийн баруун уурхайн олборлолт эхэлсэн ба тухайн сарын 25-ны өдөр Цанхийн баруун уурхайн нүүрсний экспорт эхэлсэн.
- 2015 оны наймдугаар сарын 18-нд гаалийн хяналтын бүсийн албан ёсны код авч Цанхийн талбайд гаалийн хяналтын бүс байгуулагдсан.



MV-011953

Тавантолгой ордын Бортээг болон Оорцогийн хэсгийг 2017-2019 оны хооронд нарийвчилсан хайгуулын төвшинд хүргэсэн.

MV-011952

БОРТОЛГОЙ
Нийт 389 сая тн
К-310 сая тн
ЭХ-79 сая тн

MV-011955

онцхараат
Нийт 659 сая тн
К-560 сая тн
ЭХ-99 сая тн

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд:

Цэвэр нүүрс 6.31 тэрбум

Чулуун үетэй 6.98 тэрбум

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Геологи, хайгуулын хэлтэс.

- Ордын хэмжээнд нийт 1 сая тууш метрийн өрөмдлөгийн ажил хийх шаардлагатай.
- 2013-2014 онд Цанхийн хэсэгт 40.000 тууш метрийн өрөмдлөгийн ажил хийж гүйцэтгэсэн бол 2017-2019 онд Цанхийн хэсэгт 28.000 тууш метр, Бортээг, Оорцогийн хэсэгт 112.300 тууш метр хайгуул, судалгааны ажлыг тус тус гүйцэтгэсэн.
- 2019-2020 онд Цанхийн болон Бортээгийн хэсэгт ашиглалтын хайгуулын 50.000 тууш метр геологи судалгааны ажил хийхээр төлөвлөж байна.



Хайгуулын ажлыг амжилттай гүйцэтгэж дараах үр дүнд хүрэв

- Хайгуулын мэдээлэлд тоон болон чанарын үнэлгээ, мэдээллийн сангийн менежмент, баталгаажуулалт хийлээ
- Орд газрын 2 болон 3 хэмжээст геологи, нүүрсжилтийн загварчлал боловсруулав.
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн кодын дагуу ангилал, тайлан гаргах бэлтгэл ажлыг гүйцэтгэлээ.
- ТЭЗҮ хийгдэх хүртэлх төслийн бүхий л үе шатанд нөөцийн тооцоо, ангилал, тайланг хийж гүйцэтгэв.



ДЭЛХИЙН ЖИШИГ УУРХАЙ

2010.12

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг УИХ, Засгийн газрын шийдвэрийн дагуу байгуулж, тусгай зөвшөөрөл олгов.

2011

Цанхийн зүүн уурхайн ТЭЗҮ-г батлуулан, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэв.

2011.07

Чалко компанитай гэрээ байгуулж **$350 сая** долларын урьдчилгаа төлбөр авав.

2011.08

Тавантолгойн орд газрыг JORC үнэлгээгээр **7.4 тэрбум** тонн нөөцтэйг тогтоосон.

2012.04

Монгол Улсын бүх иргэнд 1072 ширхэг хувьцааг эзэмшүүлж, аж ахуйн нэгжүүдэд худалдсан.


2013.06

Цанхийн баруун уурхайн үйл ажиллагааг эхлүүлж, гүний гаалиас борлуулж эхлэв.

- Төрийн өмчит “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь УИХ, Засгийн газрын шийдвэрийн дагуу 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр байгуулагдсан.
- “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь Монгол Улсын хамгийн олон буюу **2.5 сая** хувьцаа эзэмшигчтэй, **7.4 тэрбум** тонн нүүрсний нөөц бүхий Тавантолгойн ордод үйл ажиллагаа явуулдаг.
- 2017-2018 онд Чалко компанийн **350 сая ам.доллар**, Хөгжлийн банкны **200 сая ам.долларын** өрийг бүрэн барагдуулаа.
- “Эрдэнэс-Тавантолгой” ХК 2019 онд **1 тэрбум ам.долларын** борлуулалтын орлоготой ажиллав. Энэ бол жилийн төлөвлөгөөгөө **17** хувиар давуулан биелүүлсэн үзүүлэлт юм. Бид Монгол Улсад анх удаа борлуулалтын орлого нь **нэг тэрбум ам.доллар**, жилийн цэвэр ашиг нь **1 их наяд** төгрөг хүрсэн компани боллоо.

"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ"

2010-2020



2019 ОНЫ ОНЦЛОХ АМЖИЛТ





ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН ШИНЭ АМЖИЛТ ГАРГАВ

“Эрдэнэс-Тавантолгой” Хувьцаат компани 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдөр **50 сая** дахь тонн нүүрсээ, 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр **60 сая** дахь тонн нүүрсээ олборлолоо.

“Эрдэнэс-Тавантолгой” Хувьцаат компани 2019 онд **2.66 их наяд** төгрөгийн орлоготой ажиллаж, Монгол Улсдаа анх удаа **НЭГ ТЭРБУМ** ам.долларын борлуулалтын орлоготой компани болсон.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь “Их говийн илч” ХХК-тай хамтран сайн чанарын нүүрс угаан баяжуулж, нэмүү өртөг шингэсэн анхны бүтээгдэхүүнээ 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн экспортолж эхэллээ.





ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ ОЛОН УЛСАД ҮНЭЛЭГДЭВ

Чанарын удирдлагын тогтолцооны **ISO 9001:2015**, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны **ISO 45001:2018**, Байгаль орчны удирдлагын тогтолцооны **ISO 14001:2015** стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, баталгаажуулалтын гэрчилгээгээ 2019 оны 9 сард Франц улсын Парис хотноо гардан авлаа.

“Эрдэнэс-Тавантолгой”ХК-ний Дэлхийн жишигт уул уурхай болох зорилтын хүрээнд НҮБ-ийн "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал", хариуцлагатай уул уурхайтай холбоотой олон улсын 23 стандарт баримт бичгүүд, болон Канадын Уул Уурхайн Ассоциацын гаргасан "Тогтвортой уул уурхайн үнэлгээний заавар"-т үндэслэн Хариуцлагатай уул уурхайн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг үндсэн **5** хэсэг нийт **248** асуулттайгаар боловсруулан хэрэгжүүлж байна.



ISO 9001:2015
ISO 14001:2015
ISO 45001:2018



АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙГ АМЖИЛТААРАА МАНЛАЙЛАВ

“Эрдэнэс-Тавантолгой” ХК "Шилдэг менежмент"-тэй компаниар шалгарч, Монгол улсын "ТОП-100" аж ахуйн нэгжийг тэргүүлж эхэллээ.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд дээр ТӨБЗГ болон хараат бус ТББ-уудаас хамтран зохион байгуулдаг “Компанийн засаглалын үнэлгээ”-д хамрагдаж “**САЙН**” үнэлгээ авч, **69%**-ийн үнэлгээгээр төрийн өмчит компаниудыг тэргүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоолоор зохион байгуулагдсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-т амжилттай хамрагдаж **94.6** хувийн үнэлгээ авлаа.



БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ӨРНҮҮЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭВ

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад **357 тэрбум** төгрөг, Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад **308.9 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалт хийж төмөр замын бүтээн байгуулалтын ажил эхэллээ.

"Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн уурхайгаас Гашуун сухайтын авто замтай холбох олон улсын стандартад нийцсэн **8.2 км** хатуу хучилттай авто замыг ашиглалтад орууллаа.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор “Тавантолгой түлш” ХХК-ийг байгуулж **111.8 тэрбум** төгрөгний санхүүжилт олгож, утааг **55** хувиар буурууллаа.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай “Эрдэнэс-Тавантолгой Майнинг” охин компанийг үүсгэн байгуулав.



АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭВ

Ажилтны хөдөлмөр эрхлэлт, ажил, амралт, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, цалин хөлс, сургалт хөгжлийн талаар Үйлдвэрчний эвлэлтэй 2018 онд байгуулсан 9 бүлэг 97 заалт бүхий ЭТТ-2018/140 дугаар “Хамтын гэрээ”-ний хэрэгжилтийг 2 талаас **95.6** хувьтай дүгнэсэн амжилттайгаар 2019 оныг үдлээ.

2019 онд нийт ажилтнуудын цалинг **25** хувиар нэмэгдүүлж, Ажилтнуудад 4 сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний үр дүнгийн урамшуулал, шагнал цалин олголоо.



ИРГЭДИЙН 1072 ШИРХЭГ ХУВЬЦААГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛЛАА

Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Хуримтлалтай Хувьцаатай иргэн” аяныг амжилтай зохион байгуулж, **604** удаагийн уулзалт, сургалтаар **40 864** иргэнийг, **301** удаагийн сургалтаар зохион байгуулж **6406** албан хаагчийг хамруулж, **33 130** иргэнээс дэлгэрэнгүй судалгаа авч, **15 000** гаруй иргэний хувьцааны баримтыг цахимжуулсан байна.

Иргэдийн 1072 ш хувьцаанд ногдол ашиг олгох боломж бүрдэж, иргэн бүрт 96 мянган төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэлээ.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, УДИРДЛАГА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр амжилттай зохион байгуулж, Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланд өгсөн дүгнэлтийг батлууллаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

БАНЗРАГЧ БАЯРСАЙХАН
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

МЯНГАА БАЯРАА
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

УРГАМАЛ БЯМБАСҮРЭН
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

САНЖАА НАРАНЦОГТ
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

РЭНЦЭНДОРЖ МЭРГЭН
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

ЦЭНДДАВАА БАЯР-ЭРДЭНЭ
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

БАТТУЛГА ГАНХУЯГ
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

ЦОГ ГАНБОЛД
Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн

ПҮРЭВТОГТОХ ӨЛЗИЙНАРАН
Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн

РАДНАА БУРМАА
Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн

ХАЯНГАА БОЛОР-ЭРДЭНЭ
Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн



Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 7, хараат бус 4, нийт 11 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2019 онд 27 удаа зохион байгуулж 91 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Дээрх хурлуудаар хэлэлцсэн асуудлаар нийт 67 тогтоол гаргаж, хуралдаан тус бүрээр хураангуй тэмдэглэл 27, дэлгэрэнгүй 27 тэмдэглэлийг (1880 хуудас бүхий) хөтлөн албажуулсан байна. 2019 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо 14 удаа, Цалин урамшууллын хороо 4, Нэр дэвшүүлэх хороо 7, Хөгжил төлөвлөлтийн түр хороо 4 удаа тус тус хуралдаж, 42 асуудлыг хэлэлцэж 29 дүгнэлт, зөвлөмж гаргасан байна.


2019 онд ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалтай холбоотой 4 журмыг шинэчлэн, 5 журмыг шинээр боловсруулж, нийт 9 журмыг ТУЗ-ийн тогтоолоор баталжээ.

КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Компани нь Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал, **5** дэд захирал, **19** хэлтэс, **1** салбартайгаар нийтдээ **755** ажилтан, албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна. Компанийн ажилчид нь **100** хувь Монгол улсын иргэд бөгөөд **22** хувь нь Өмнөговь аймгийн харьяат иргэд байна.

Монголын компанийн засаглалын кодекс, гадаадын жишиг компаниудын сайн засаглалын туршлагаас суралцан Сайн засаглалыг нэвтрүүлэх, компанийн засаглалаар манлайлах зорилт тавин ажиллаж байна.

Компанийн засаглалын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, оролцогч талуудад зөв ойлголт, мэдээлэл өгөх зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас компанийн засаглалын үнэлгээг эдийн засаг хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын (OECD) компанийн засаглалын зарчмууд, түүнчлэн Монгол улсын компанийн засаглалын эрх зүйн зохицуулалтыг тусгасан асуултаар үнэлсэн. “Эрдэнэс-Тавантолгой” ХК "**Сайн**" үнэлгээ авч, **69** хувиар төрийн өмчит компаниудыг тэргүүллээ.



Эх сурвалж: Компанийн засаглалын үнэлгээний тайлан

Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамжаар “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-т анх удаа хамрагдан **94.6** хувийн үнэлгээ авч, Төрийн өмчит компани, улсын үйлдвэрийн газар, төсөвт **32** байгууллагаас **5** дугаар байрт шалгарчээ.

“ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ – УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ”

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь өнгөрсөн хугацаанд компанийн дунд хугацааны бодлогын баримт бичиг болох бизнес төлөвлөгөөг 4 жилийн давтамжтайгаар батлуулж, мөрдөн ажиллаж ирсэн боловч компанийн хөгжлийн нэгдсэн стратеги буюу урт хугацааны бодлогын баримт бичиггүй явж ирсэн.

Иймд компанийн ирээдүйн хөгжлийн зорилтыг зах зээлийн чиг хандлага, компанийн уул геологийн ирээдүйн нөхцөл байдал, төрөөс хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл хөтөлбөрүүд, түүнчлэн улс орны тогтвортой хөгжлийн бодлого зэрэгтэй уялдуулан оновчтой тодорхойлсон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг бодитоор боловсруулан батлуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/307 тоот тушаалаар компанийн хөгжлийн стратегийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, Монгол Улсын Их сургууль болон Санхүү Эдийн засгийн их сургуулийн багш, доктор, профессоруудаас бүрдсэн мэргэжлийн судлаачдын багтай хамтран судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.



"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Хөгжлийн Стратеги: Урт хугацааны бодлогын баримт бичиг" -ийн төслийг Захирлын зөвлөлийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүсэн бөгөөд Үндэсний хөгжлийн газрын холбогдох ажилтнууд, УУХҮЯ -ны газар, хэлтсийн дарга нарт тус тус танилцуулаад байна.

Ажлын хэсгийн зүгээс гадаад орчны судалгааг эдийн засаг, санхүүгийн орчин болон коксжих нүүрсний зах зээлийн томоохон тоглогч болох БНХАУ, зарим өрсөлдөгчдийн судалгааг нарийвчлах замаар хийсэн. Компанийн дотоод орчны судалгааг **"Үнэ цэнийн гинжин хэлхээ"**-ний загвар, **Портерийн 5** хүчин зүйлийн моделийн зарим орцууд, **SWOT, TOWS** шинжилгээний загвар ашиглан хийж гүйцэтгэв.

Ийнхүү судалгааны ажлын үр дүн, нөхцөл байдлын шинжилгээний дүгнэлтэд үндэслэн "Эрдэнэс-Тавантолгой" ХК нь урт хугацаанд баримтлах бизнесийн стратегийг онолын түвшинд гадны компаниудын түгээмэл ашигладаг стратегийн гол 5 чиг хандлагаас бизнесийн хөгжлийн эхэн үед үйл ажиллагаа эрхэлж буй компаниуд болон уул уурхайн салбарын компаниудын хувьд түлхүү баримталдаг **"Өртгөөр давамгайлах хямд үнийн стратеги" /Cost leadership strategy/** -ийг баримтлан ажиллах нь зүйтэй гэж тодорхойлоод байна.

Энэ нь зардлын удирдлагын сахилгыг дээд түвшинд барих замаар өртөг бууруулж, хуримтлал үүсгэх, улмаар үйлдвэрлэлийн зардлыг бууруулж, шаардлагатай төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг бүрдүүлэхэд чиглэгддэг стратеги юм.

Түүнчлэн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн зүгээс урт хугацааны стратегийг хэрэгжүүлэхэд баримтлах стратегийн дараах 3 гол чиглэлийг баримтлан ажиллахаар төлөвлөөд байгаа юм. Үүнд:

1. **Сайн чанарын коксжих нүүрсний нөөцөд түшиглэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгож, өртгөөр давамгайлах стратегийг баримтлах;**
2. **Зах зээлийг тэлж, эцсийн хэрэглэгчдэд хүрч ажиллах стратегийг баримтлах;**
3. **Компанийн тогтвортой хөгжлийг урт хугацаанд хадгалах стратегийг баримтлах гэж тодорхойлсон.**

ДЭЭД ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭР, ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагаатай холбоотой гарсан УИХ-ын тогтоол, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар 40 шийдвэрийн хэрэгжилтийг ханган, биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр гарган, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тайлагнаж, төр засгийн шийдвэрийг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, компанийн засаглалыг сайжруулах зорилгоор Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, Хүний нөөцийн бодлогын баримт бичиг, Хэвлэл мэдээлэл, олон нийтийн чиглэлээр баримтлах бодлогын баримт бичгийг тус тус боловсруулан, батлуулж ажиллалаа.

Үйлдвэрлэлийн зардал бууруулах, үр ашиг бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Төсөв боловсруулах, зарцуулалтад хяналт тавих журам", компанийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор "Дотоодын болон гадаадын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалахтай холбоотой зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журам", үндсэн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах зорилгоор "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн дотоод хяналт шалгалтын зохион байгуулах журам", "Гэрээ, санамж бичгийн журам", "Нүүрс борлуулах үйл ажиллагааны журам" "Ажил хүлээлцэх журам", "Цахим баримт ашиглалтын журам", "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн мэдээлэл боловсруулж түгээх, хэвлэл, мэдээллийн байгууллага, олон нийттэй харилцах журам"-уудыг шинээр боловсруулж батлуулж, 13 журамд нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчиллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2017-2020 оны Бизнес төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилттой уялдуулан компанийн төсөв, хөрөнгийн эх үүсвэрийн боломжид тулгуурлан үндсэн үйлдвэрлэл, уулын ажил, геологи хайгуул, маркетинг, борлуулалт, худалдан авах ажиллагаа, стратеги төлөвлөлт, хувьцаа, эдийн засаг, санхүү бүртгэл, дэд бүтэц, төсөл хөтөлбөр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр 2019 онд нийт 32 хөтөлбөрийн хүрээнд 124 ажил, арга хэмжээг төлөвлөн амжилттай хэрэгжүүллээ.

Компанийн Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ирлээ. Компанийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах ажлын хүрээнд Захирлын зөвлөлийн хурал 26 удаа хуралдаж, 83 асуудал хэлэлцэн, шийдвэрлэсний гадна удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 46 удаа хийж, 230 үүрэг даалгавар гүйцэтгэлийг бүрэн хангаж ажилласан.

Шилэн дансны тухай" хууль болон "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу 5 төрлийн мэдээллийг www.shilendans.gov.mn сайтад, 11 төрлийн мэдээллийг компанийн www.ett.mn сайтад тогтмол байршуулан ажилласан.



ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА


НҮҮРС ОЛБОРЛОЛТ, ГЕОЛОГИ ХАЙГУУЛ

Цанхийн уурхайгаас 2019 онд **16.2** сая тонн нүүрс олборлож, **77.3** сая м^3 уулын цулын ажил гүйцэтгэсэн нь 2018 оны энэ үетэй харьцуулахад нүүрс олборлолт **46** хувь, уулын цулын ажил **30** хувиар өссөн үзүүлэлт юм.

Тавантолгойн бүлэг ордод Австрали улсын JORC болон Канад улсын **NI 43-101 (National Instrument 43-101)** стандартын дагуу олон улсын нөөцийн тайлан боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

Цанхийн хэсэгт ашиглалтын хайгуулын **15,000** тууш метр, Бортээг, Оорцогийн хэсэгт нарийвчилсан хайгуулын **62,300** тууш метр нийт **77,300** тууш метрийн өрөмдлөг, геофизик, геологийн боловсруулалт судалгааны ажлыг хийж гүйцэтгэжээ.


График: Нүүрс олборлолт (сая тонн)



НҮҮРС БОРЛУУЛАЛТ


“Эрдэнэс-Тавантолгой” ХК 2019 онд **15.5** сая тонн нүүрс борлуулж, **2.66 их наяд** төгрөг буюу **1,000.45 сая** ам.долларын борлуулалтын орлоготой ажилласнаар өмнөх онтой харьцуулахад борлуулалтын хэмжээ **18%**-иар, борлуулалтын ам.долларын мөнгөн орлого **25%**-иар, борлуулалтын төгрөгийн мөнгөн орлого **34%**-иар өссөн үзүүлэлттэй байна.

График: Борлуулалтын орлого ба борлуулсан нүүрсний хэмжээг графикаар үзүүлэв.




Энэ оны 3-р сард **1.7 сая** тонн нүүрс борлуулахаар ачуулсан нь компанийн түүхэнд 1 сард хамгийн их нүүрс ачуулсан үйл явдал болсон юм.

График: Борлуулалтын төлөвлөгөө ба гүйцэтгэлийг сар тус бүрээр харуулав



“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь 2019 оны борлуулалтын хэмжээ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **18%**-иар өссөн үзүүлэлттэй байна.

График: Цанхийн уурхайн борлуулалтын хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулан харуулав /мянган тонн/



Энэ оны борлуулалтын орлого нь **2.66** их наяд төгрөг буюу, **1,000.45** сая ам.доллар хүрсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад **1.3** дахин өссөн үзүүлэлттэй байна. Мөн 11-р сараас бусад саруудад борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс өссөн байна.

Энэ онд нийт **63** борлуулалтын гэрээ хэрэгжсэнээс **22** гэрээ бүрэн хэрэгжиж дуусжээ. Нийт хэрэгжиж буй гэрээнүүдийг төлбөрийн зэрэг баланстайгаар хэрэгжүүлсэн.

Компанийн үйл ажиллагаа эхэлсэн 2011 оноос хойш 2019 оныг өдөр хүртэл нийт хугацаанд **59.1** сая тонн буюу **7.33** их наяд төгрөгийн мөнгөн дүн бухий нүүрсийг борлуулж, экспортод гаргаад байна.

2019 оны нийт борлуулалтын 64% буюу 9.89 сая тонн (Үүнд коксжих 9.4 сая тонн, исэлдсэн 0.5 сая тонн) нүүрсийг Цанхийн зүүн уурхайгаас, 36% буюу 5.6 сая тонн коксжих нүүрсийг Цанхийн баруун уурхайгаас нийлүүлсэн байна.

Цанхийн уурхайн олборлолтын технологийн явцад гарсан хаягдал, ул таазны хаягдал, балансын бус нимгэн үе давхаргаас гарсан нүүрс, хагарал, тэсэлгээний явцад үүссэн хаягдал зэрэг балансын бус бохирдолтой нүүрсийг борлуулахаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Нүүрс борлуулалт, экспортын үр ашгийг нэмэгдүүлэх, ЭТТ брэнд бий болгох, уурхайгаас олборлож буй бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын нүүрс баяжуулах үйлдвэрүүдэд нэмүү өртөг шингээн, БНХАУ-ын Хэбэй мужийн зах зээлд хүргэн өрсөлдүүлэх, цаашлаад Цаофэйдянь боомтоор ре-экспорт хийж олон улсын гуравдагч зах зээлд экспортлох зорилтын хүрээнд хамтран ажиллагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан компанитай туршилтын гэрээг байгуулсан.


Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг гэрээний үнээр тооцуулах ажлыг зохион байгуулж 2019 оны 1-11 сарын хугацаанд Сангийн яамнаас зарлагдсан “Экспортод гаргасан ашигт малтмалын олон улсын зах зээлийн үнийн мэдээлэл”-д дурдагдсан коксжих нүүрс болон исэлдсэн нүүрсний үнэ нь манай борлуулж буй үнээс өндөр байсан учраас АМНАТ-ыг гэрээний үнээр тооцоолон тайлан мэдээг боловсруулж, хүргүүлсэн.

Исэлдсэн нүүрсний борлуулалтыг нэмэгдүүлэхээр нүүрс

худалдан авагчийн сонгон шалгаруулалт зарласан ба 2019 онд нийт **2020** мянган тонн исэлдсэн нүүрс худалдах, худалдан авах гэрээг шинээр байгуулж, **507.5** мянган тонн нүүрсийг худалдан авагчид нийлүүлсэн байна.


Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 35.11 дэх заалтыг харгалзан дотоодын аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан компаниудтай гэрээ байгуулан ажиллаж, манай компанийн уурхайгаас нийлүүлж буй нүүрсийг нэмүү өртөг шингээн экспортлох боломжийг бүрдүүлэв. Монгол Улсын Оюуны өмчийн газраас "чулуун нүүрс" ангилалд барааны тэмдэгт эзэмшиж эхэллээ.

График: CR China Coking Coal Price Index



Нүүрсний зах зээл 2019 оны 7 дугаар сараас хойш уналттай байсан бөгөөд зорилтот зах зээлийн коксжих нүүрсний дундаж үнийг илэрхийлдэг "CR China Coking Coal Price Index"-тэй дээрх графикаас танилцана уу.

График: Баруун Цанхийн борлуулалтын үнэ /ам.доллар/




Цанхийн Баруун уурхайн нүүрсний үнийг оны эхэн үеийн үнэ буюу 71.25 ам.доллараас шат дараатай, тодорхой хэмжээгээр өсгөж, нүүрсийг тонн тутмыг нь 71.25-71.75 ам.долларын хооронд борлуулж байсан боловч 4-р улиралд олон улсын зах зээлд болон БНХАУ-ын хамаарал бүхий боомтуудад нүүрсний үнэ огцом унаснаас шалтгаалж 64.07 ам.доллараар үнийг тогтоосон.

График: Чалко компанийн үнэ /ам.доллар/




Цанхийн Зүүн уурхайгаас БНХАУ-ын төрийн өмчит Чалко Трейдинг Хонконг компанид нийлүүлж буй нүүрсний үнийг индекс тооцох аргачлалын дагуу улирал тутам тооцоолон гаргаж, 58.2-63.32 ам.долларын хооронд нийлүүлж ажиллалаа.

График: БНХАУ-ын коксжих нүүрсний импортод Монгол улсын эзлэх хувь /сая тн/



Зорилтот зах зээл болох БНХАУ-ын коксжих нүүрсний импортын хэмжээ өмнөх оны мөн үеэс **9.6 сая** тонноор нэмэгдэж **74.7 сая** тонн болсон. Монгол улс **33.8 сая** тн коксжих нүүрс экспортлосон нь тус улсын коксжих нүүрсний нийт импортын 45 хувийг дангаараа бүрдүүлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад **6.9 сая** тонноор өссөн үзүүлэлт юм.

График: Монгол улсын нүүрсний экспортод "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн эзлэх хувь /сая тн/



Графикаас "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн нүүрс экспортын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгааг харж болохоор байгаа ба 2018 онд нийт **13.1 сая** тн нүүрс борлуулсан бол 2019 онд **15.5 сая** тн нүүрс борлуулаад байна.



ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



2019 онд нийт **52** худалдан авагчтай байгуулсан **63** борлуулалтын гэрээний хүрээнд 216 тээврийн компанийн **8068** тээврийн хэрэгсэлд **14,568,221** тн нүүрс ачиж тээвэрлэжээ. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад тээврийн компанийн тоо **28.5** хувиар, тээвэрлэсэн нүүрсний хэмжээ **11** хувиар өссөн үзүүлэлт юм.

Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээг **170** аж ахуйн нэгжтэй байгуулсан бөгөөд хучилтын гэрээг нүүрс тээврийн **95** аж ахуйн нэгж, **23** худалдан авагчтай хийж гүйцэтгэлийг хангуулан ажиллажээ.

Энэ оны онцлох бүтээн байгуулалт нь Уурхайгаас Гашуун сухайтын чиглэлийн авто зам хүртэлх **8.2** км олон улсын стандартад нийцсэн хүнд даацын хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн явдал бөгөөд 8 метрийн зорчих хэсэгтэй, 3.5 метрийн хөвөөтэй нийт 15 метрийн өргөнтэй, 48 см-ийн хучилтын хийцтэй уг зам ашиглалтад орсноор жолооч нарын аюулгүй, ая тухтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулахад эерэг нөлөө үзүүлж байна.

Нүүрс тээврийн дэд бүтцийг сайжруулах зорилгоор 2019 онд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн санхүүжилтээр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт өрнөж, Тавантолгой-Гашуун сухайтын төмөр замын ажил эхэлсэн.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад **357** тэрбум төгрөг, Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад **308.8** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ



“Эрдэнэс-Тавантолгой” ХК 2019 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны олон улсын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр баталгаажуулалтын сертификатаа гардан авсан. Энэ онд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар журмыг чанд мөрдөн ажиллаж үйлдвэрлэлийн осол, болзошгүй аюулаас бүрэн урьдчилсан сэргийлэн ажилласан.

“Эрдэнэс-Тавантолгой” болон гэрээт компанийн **3967** ажилтнуудыг ХАБЭА-н 4 төрлийн сургалтад хамруулжээ. Шинэ ажилтны сургалтад **2211**, жолооны сургалтад **479**, мэргэшүүлэх сургалтад **1189**, түр ажиллах ажилтны сургалтад **88** ажилтныг тус тус хамруулсан байна.

“Аваар устгах төлөвлөгөө”, “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г танилцуулах сургалтыг 2019 оны 03, 04 дүгээр сард зохион байгуулж **451** ажилтан, “Гал унтраах дадлага сургуулилт”-ыг 2019 оны 09 дүгээр сарын 05-28-ны хооронд зохион байгуулж 4 ээлжийн **454** ажилтныг тус тус хамруулав.



БАЙГАЛЬ ОРЧИН, УСНЫ БОДЛОГО, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Байгаль орчныг хамгаалах, усны зохистой хэрэглээг бий болгох асуудал эн тэргүүний зорилт хэмээн үзэж, энэ чиглэлээр компанийн нийгмийн хариуцлагыг чиглүүлэн ажиллаж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2019 онд байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөлийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулан Цанхийн уурхайн үйл ажиллагаанд хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл, эвдрэл нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллалаа.

2019 онд Байгаль орчны удирдлагын тогтолцооны MNS:ISO 14001 стандартыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Франц Улсын Афнор группээс баталгаажуулалтын гэрчилгээгээ гардан авсан.

КОМПАНИЙН УС АШИГЛАЛТЫН БАЙДАЛ

Уурхайн хэмжээнд нийт гүний усны 21-н худаг байгаагаас 12 худаг ашиглагдаж байна. 2019 онд гүний худгаас нийт **296.3** мянган тонн ус ашигласан байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн зориулалтаар – **254.1** мянган тонн ус;
- Ахуйн хэрэглээний зориулалтаар – **35.0** мянган тонн ус;
- Мод усалгааны зориулалтаар – **85.7** мянган тонн усыг ашигласан байна.

Цанхийн баруун, зүүн уурхайгаас шавхан зайлуулсан буюу шүүрлийн ус **61.9** мянган тонн, хурын борооны тогтсон ус **168.2** мянган тонн усыг тоосжилт дарах зорилгоор зам усалгаанд ашигласан байна.







Хүснэгт: Компанийн усны хэрэглээ (мянган литр)

Сар	Ахуйн	Үйлдвэрийн	Ойжуулалт	Зам усалгаа	Эх үүсвэр			Бүгд
					Худаг	Шүүрэл	Хурын ус	
I	3494	8829			12323		13698	26021
II	3533	6605		3	10141		12116	22257
III	4355	13663	46	504	18568		17119	35687
IV	3647	8166	229	1020	13063	16038	33940	63040
V	4120	7860	817	1047	13844	26772	34316	74932
VI	3608	13269	1455	583	18915	12160	35899	66974
VII	3172	36156	1563	46	40940	4130	3900	48970
VIII	3102	58555	1560	-	63217		3880	67097
IX	3235	51588	604	-	55427	2585	5072	63084
X	2746	46196	0	971	49913	242	8320	58475
НИЙТ	35015	254091	85719	7245	296350	61927	168260	526537

ТООСОНЦОРЫН АГУУЛАМЖИЙН ХЭМЖИЛТ

Уурхайн үйл ажиллагааны явцад үүсэж буй тоосжилтыг бууруулах зорилгоор 2019 оны 06 дугаар сарын 25-ний өдрөөс гэрээт компаниудад тоосжилт бууруулах 1 сарын аян зарлан ажиллалаа. Тус аяны хүрээнд сул хөрс, түйрмийг тогтмол хусаж цэвэрлэх, усалгааны давтамж нэмэгдүүлэх, технологийн замуудад хайрга болон улаан шороог дэвсэх зэрэг ажлууд хийж гүйцэтгэсний үр дүнд 5 цэгт хэмжилт хийхэд тоосжилт 10-50 хувиар буурсан үзүүлэлт гарчээ.

Хэмжилтийг уурхай болон хотхоны хэмжээнд нийт 7-н цэгт Dusttrak DRX8533 болон Dusttrak DRX8533 EP багаж ашиглан 7 хоногийн 3 өдөр 24 цагийн тоосны хэмжилт хийж байна.

УРГАМЛЫН МОНИТОРИНГ

2014 оноос Таван толгойн төслийн талбайд ургамлын бүлгэмдлүүдийг илэрхийлж чадах 3 трансектийн дагуу нийт 19 цэг сонгон жилд 2 удаа үзэгдэл зүй болон ургацын хэмжилт хийж байна. Мониторингийн цэгүүдэд 3 удаагийн давталттайгаар 1 м^2 талбайн ургамлын бүрхэц, зүйлийн бүрэлдэхүүн, арви, өндөр, ургацын жин зэргийг хэмжив.



НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТУРШИЛТ



Компанийн зүгээс уурхайчдын хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор говийн хөрсөнд буудай, юуцай, салатны навч, редиск тариалан хураан авч уурхайн ажилчдын хүнсэнд хэрэглэж байгаа бөгөөд гүзээлзгэнэ, ногоон сонгино тариалсан нь амжилттай ургаж байна.

Үйл ажиллагаа эхэлсэн цагаас хойш Цанхи хотхон, Эрдэнэс хотхон болон хотхон дундах цэцэрлэгт хүрээлэн, уурхайн оффисын гадна талбай, зочдын тавцан, мод үржүүлгийн талбай зэрэгт нийт **100972** ширхэг мод тарьсан. 2019 онд **63000** ширхэг мод тарьжээ.

ШОРООН НҮҮРС ТЭЭВРИЙН ЗАМЫН ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Цанхийн уурхайгаас Гашуунсухайт чиглэлийн автозамтай холбогдох **8.2** км хатуу хучилтай зам ашиглалтад орсноор хуучин нүүрс тээврийн **10.2** км зам ашиглалтнаас гарч нөхөн сэргээх нөхцөл бий болсон. Компанийн зүгээс замын нөхөн сэргээлтийн төлөвлөлтийг боловсруулж, хуучин замын тэлэлтэнд өртөхгүй хэсгийн **7** км замыг тэгшилж шимт хөрс дэвсэн техникийн нөхөн сэргээлт хийлээ.





ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


ЭДИЙН ЗАСАГ САНХҮҮГИЙН БАЙДАЛ

2019 онд “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь **1** тэрбум ам.долларын буюу **2.66** их наяд төгрөгийн борлуулалтын орлого олж, **1** их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад **42** хувиар, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **28** хувиар тус тус өссөн байна.

Компанийн үйл ажиллагаа өргөжин тэлж, төсөл хөтөлбөрүүдийг эрчимжүүлж борлуулалт нэмэгдэн, ашигт ажиллагаа өсөнөөр компанийн нийт хөрөнгийн хэмжээ **1.0** их наяд төгрөгөөр нэмэгдэн **13.4** их наяд төгрөгт хүрсэн.


Улсын төсөвт **736.1** тэрбум төгрөгийн татвар, хураамжийг төвлөрүүлснээр батлагдсан төлөвлөгөөг **41** хувиар давуулан биелүүлж, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **53** хувиар өсчээ.

График: Компанийн цэвэр ашиг, Улсад төлсөн татвар хураамж /тэрбум төгрөг/




Улсын нэгдсэн төсөвт 2019 онд **719.4** тэрбум төгрөгийн татвар хураамжийг төвлөрүүлсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **54.2** хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Төсөвт төвлөрүүлсэн татварын мөнгөн дүнг графикаар харуулав.

График: Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж /сая төгрөг/



Орон нутгийн төсөвт “Эрдэнэс-Тавантолгой” ХК 2019 онд **16.7** тэрбум төгрөгийн татвар хураамжийг төвлөрүүлснээс **10.9** тэрбум төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэл эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **61.8** хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм.

График: Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж/сая төгрөг/



Компани олборлолтыг бүрэн хүчин чадалд хүргэх, өртөг зардлыг бууруулан өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тээвэр логистикийн найдвартай сүлжээг бий болгох, хөрөнгө оруулалтыг үр ашигтай оновчтой байдлаар хэрэгжүүлэх нэгдсэн бодлогын хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд нийт **665.9** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг олгоод байна.

Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх “Тавантолгой түлш” ХХК-ийн 2019 оны хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, үйл ажиллагаанд шаардагдах **111.8** тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Тавантолгой ордыг цогцоор нь хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөрөнгө оруулалтыг үр ашигтай оновчтой байдлаар хэрэгжүүлэх нэгдсэн бодлогын хүрээнд Баяжлуулах үйлдвэр, Усны төсөл, Конвейрийн төсөл, терминал төв байгуулах зэрэг төсөл хөтөлбөрийг эрчимжүүлж ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулах ажлууд хийгдэж байна.

Батлагдсан төсвийн хүрээнд компанийн худалдан авалт, ажилтнуудын томилолт, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахад хяналт тавьж бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах нийт **532** захиалгын хуудас, **352** удаагийн томилолтын төсөв, сургалт, уулзалт, олон нийтийн арга хэмжээний **135** удаагийн захиалгыг тус тус төсвийн дагуу боловсруулж шийдвэрлэсэн. Төсвийн гүйцэтгэл, биелэлтийг улирал бүр гаргаж, төсөв хэтэрсэн хэмнэсэн шалтгааныг тодруулан холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулж компанийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад шаардлагатай бараа, ажил үйлчилгээг батлагдсан төсөвт өртгийн хүрээнд худалдан авах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Худалдан авалтыг зохион байгуулахдаа ил тод, нээлттэй, тэгш өрсөлдөх боломжийг хангаж ажиллах, зах зээлийн бодит үнээр чанартай бараа материал худалдан авах, компанид үр ашигтай, хэмнэлттэй байх, хууль тогтоомжийн хүрээнд хариуцлагатай байх зарчмыг мөрдлөг болгон ажилласан.

2019 оны Худалдан авалтын төлөвлөгөөний дагуу нийт **157** тендер шалгаруулалтаар **2.04** их наяд төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний тендер зарлаж, **1.95** их наяд төгрөгийн гэрээ байгуулж, **94.2** тэр бум төгрөгийн хэмнэлт гаргажээ.

3 жилийн хугацаатай хийгдэх “Цанхийн баруун уурхайн олборлогчийг сонгох” **2.89** их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 багцтай тендерээс 3 багцад **1.89** их наяд төгрөгийн гэрээ байгуулж, **88.65** тэрбум төгрөгийг хэмнэсэн.

Дотоодын аж ахуйн нэгж байгууллагаас **1.086** тэрбум төгрөгийн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдан авсан байна.

Хүснэгт: 2019 оны Худалдан авах ажиллагааны мэдээллийг хүснэгтээр харуулав

	Тендер шалгаруулалтын журам	Батлагдсан нийт төсөв Мян, төг	Гэрээний үнийн дүн Мян, төг	Хэмнэлт Мян, төг	Тендер шалгаруулалтын тоо	Цахим тендер шалгаруулалтын тоо
1	Нээлттэй тендер шалгаруулалт	2,027,727,077	1,934,785,454	92,941,622	60	60
2	Зөвлөх үйлчилгээний тендер	3,054,800	2,795,949	258,850	11	11
3	Харьцуулалт	2,054,204	1,862,188	192,015	64	64
4	Шууд худалдан авалт	-	504,416	-	126	-
5	Шууд гэрээ байгуулах арга	10,842,560	10,028,101	814,459	22	12
6	Нийт дүн	2,043,678,642	1,949,471,693	94,206,949	157	147

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

-УИХ-ын "Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай" 2018 оны 73 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын "Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2019 оны 296 дугаар тогтоолыг үндэслэн Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх зорилгоор **"Эрдэнэс-Тавантолгой Майнинг"** ХХК-ийг 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани хэлбэрээр үүсгэн байгуулав.

Гадаадаас хөрөнгө оруулалт татах зорилгоор олон улсад нэр хүнд бүхий **Bank of America Merrill Lynch, Nomura, Credit Suisse** зэрэг байгууллагуудыг зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж хамтран ажиллаж байна. Дотоодын хөрөнгийн зах зээлд компанийн үнэт цаасыг бүртгүүлэх бэлтгэж ажил бүрэн хангагдаж 11 зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдийг сонгон шалгарууллаа.

Үүнд:

- Андеррайтерийн зөвлөх үйлчилгээ;
- Хуулийн зөвлөх үйлчилгээ;
- Хөрөнгийн үнэлгээний тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээ;
- Аудитын зөвлөх үйлчилгээ;
- Нүүрсний зах зээлийн судалгааны тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээ;
- Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээний тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээ;
- Уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн сан бүрдүүлэх, хаалтын төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ;
- IPO гаргах чиглэлээр брэнд бүтээх, хөгжүүлэх зөвлөх үйлчилгээ;
- Мэдээллийн сан, проспектус, үнэт цаас танилцуулах зөвлөх үйлчилгээ;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээ;
- Геологийн болон ашигт малтмалын нөөцийн тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээ зэрэг багтаж байна.

САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн санхүүгийн байдал, гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн мэдээ, тайланг Монгол улсын хууль эрх зүй, олон улсын стандартад нийцүүлэн мэргэжлийн түвшинд боловсруулан ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу уурхай болон төвийн ажлын хэрэгцээнд шаардлагатай ажил, үйлчилгээ, барааны захиалгын хүүдсыг баталгаажуулах, худалдан авсан үндсэн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч нягтлан бодох бүртгэлд тусгах хөрөнгийн хөдөлгөөнийг тайлагнах, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг тухай бүр гүйцэтгэж ажилласан.

Татварын багц хуулиудын хүрээнд 2019 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын санхүүгийн тайлан, ААНОАТ, Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан, Агаарын бохирдлын тайлан, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг улирлаар, НӨАТ-ийн тайлан, Оршин суугч бус этгээдээс суутгасан НӨАТ-ын тайланг сар бүр гаргаж цахимаар илгээн баталгаажуулж, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргав.

Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу сар бүр нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, ажилчдын цалин хөлс, улирлын урамшуулал, үр дүнгийн урамшуулал, хөдөлмөрийн чадвараа түр алдсан болон жирэмсний, амаржсаны тэтгэмжийн тооцоог тухай бүр хийж, ажилчдын нийгмийн даатгалын дэвтрийн цалингийн бичилтийг сар бүр хийн, нийгмийн даатгалын байгууллагаар баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

ЗАХИРГАА, УДИРДЛАГА

Компанийн Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ирлээ.

Компанийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах, ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах ажлын хүрээнд Гүйцэтгэх захирлын **1602** тушаалыг албажуулан гаргасан бөгөөд үйл ажиллагаатай холбоотой **624** тушаал, боловсон хүчинтэй холбоотой **978** тушаал гарчээ.

Гэрээний нэгдсэн бүртгэл, бүртгэлийн цахим сан үүсгэн ажиллаж байгаа бөгөөд компанийн хэмжээнд 2019 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан нийт **814** гэрээ, **78** гэрээний нэмэлт өөрчлөлт, **201** гэрээ дүгнэсэн актыг хянаж, баталгаажуулан гэрээний нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна.

Компанийн хэмжээнд 2019 онд нийт **2038** албан бичиг, **700** өргөдөл гомдол хүлээн авсан бөгөөд хугацаанд нь шийдвэрлэж хариу өгчээ. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-аас 2019 онд нийт **3265** албан бичгийг стандартын дагуу албажуулан зохих байгууллагад нь хүргүүлэв.


“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын 4 хууль, УИХ-ын 6 тогтоол, УИХ-ын байнгын хорооны 1 тогтоол, Ерөнхийлөгчийн 1 захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 зөвлөмж, Засгийн газрын 15 тогтоол, 14 хуралдааны тэмдэглэл, 1 албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Компанийн архивд түр хадгалах хадгаламжийн **3939**, Байнга хадгалах хадгаламжийн **1352**, 70 жил хадгалах хадгаламжийн **186**, Дүрс бичлэгийн баримт буюу тусгай төрлийн баримтын **321**, Устгах хэргийн актын **854**, Геологийн **175**, нийт **6827** хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

Компанийн үйл ажиллагааны 2019 оны тайлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг улирлаар гарган УУХҮЯ-нд хүргүүлж, 2019 оны жилийн эцсийн тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар ажиллаж байна.

Хувьцаа, эзэмшигчдийн ээлжит хурлыг 1 удаа зохион байгуулж, хурлын харуул хамгаалалт, зохион байгуулалтыг ханган ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг гарган, нэгжүүдийн хэлэлцэх асуудлуудын материал, танилцуулгыг бэлтгэн хүргүүлж Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган ТУЗ-ийн ажлын албанд хүргүүлэн ажиллалаа.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, СУРГАЛТ ХӨГЖИЛ

2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 755 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаагаас төв оффист 196, салбарт 559 ажилтан ажиллаж байна.

График: Ажилчдын тоо




График: Компанийн нийт ажилтныг хүйс болон насны байдлаар ангилан авч үзвэл





График: Уурхайд ажиллаж буй ажилтнуудыг орон нутгийн харьяаллаар нь авч үзвэл



"Эрдэнэс-Тавантолгой" ХК 2019 онд ажилтан албан хаагчдын эрүүл мэндийг дэмжиж, мэдлэг ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх "Амжилтын лууэжин", "150 менежер", "Эрүүл ажилтан", "Дэлхийн жишиг уул уурхай – Эрдэнэс-Тавантолгой", "Говийн ирээдүй" сургалтын хөтөлбөрүүдийг батлуулан хэрэгжүүлж ажиллалаа.

2019 онд **89** төрлийн чиглүүлэх, дадлагажуулах, хөгжүүлэх, мэргэшүүлэх сургалтад давхардсан тоогоор **5812** ажилтныг хамруулж, **413** ажилтанд мэргэжлийн гэрчилгээ олгон, сургалтын үйл ажиллагааны төсвөөс нийт **445 088 018** төгрөг зарцуулсан байна.

Компанийн ажилчдыг мэргэжил эзэмших болон мэргэжлээ дээшлүүлэн бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцахад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж, чадварлаг боловсон хүчний бэлтгэхээр "150 менежер" хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж **44.9** сая төгрөгийн сургалтын дэмжлэг олгожээ.

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ, АЖИЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ





Компанийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн ЭТТ-2018/140 тоот хамтын гэрээний хэрэгжилтийг хамтарсан ажлын хэсэг байгуулан дүгнэлээ. Хамтын гэрээний хэрэгжилт **95,6** хувьтай дүгнэгдсэн бөгөөд нэмэлт гэрээ байгуулан ажиллаж байна.

Ажилчдын үндсэн цалинг 2019 онд үе шаттайгаар **25** хувиар нэмэгдүүлсэн нь тэдний урмыг сэргээж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлжээ. Нийт ажилтнуудад улирал бүр **500** мянган төгрөгийн урамшуулал олгох ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд үр дүнгийн болон бусад нэмэлт урамшууллыг олгож байна.

2019 онд нийт **631** ажилтанд **5,3** тэрбум төгрөгийн үр дүнгийн урамшууллыг компанид ажилласан жилээр тооцож олгожээ.

Тулгар төрийн 2228, Их Монгол Улс байгуулагдсаны **813**, Ардын хувьсгалын 98 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан ажлын амжилтаараа хамт олноо манлайлан ажилласан нийт **75** ажилтан төрийн одон медаль, шагналаар шагнагдаж Гүйцэтгэх захирлын тушаалаар **6.050.000** төгрөгийн шагнал дагалдах мөнгөн урамшуулал олголоо.

2019 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсад Уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 97 жил, “Эрдэнэс-Тавантолгой” ХК үүсгэн байгуулагдсаны 9 жилийн ойг тохиолдуулан ажлын амжилтаар хамт олноо манлайлж, эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журмыг мөрдөж, мэргэжлийн өндөр ур чадвар гарган идэвх санаачилгатай ажилласан 17 ажилтныг төрийн дээд одон медалиар шагнасан байна.

Компанийн ажилтнуудыг төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны 8%-ийн ипотекийн зээлд хамруулахад тавигдах шаардлагыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж Голомт банканд 11 албан бичгээр **52** ажилтны нэрсийг хүргүүлсэн бөгөөд шаардлага хангасан **22** ажилтны нийт **1.6** тэрбум төгрөгийн зээлийг шийдвэрлэсэн байна.

Ажилтнуудын эрүүл мэндийн байдлыг сайжруулах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг “Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг”-тэй хамтран зохион байгууллаа. Эрүүл мэндийн үзлэгт 7 удаагийн ээлжээр **761** ажилтныг хамруулжээ.

2019 онд "Эрүүл ажилтан" хөтөлбөрийн хүрээнд зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, стрессгүй орчин гэсэн 3 дэд хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, салбарын **600** орчим ажилчдыг хамруулснаар уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт энэ төрлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн анхдагч компанийн нэг болж байна.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газартай санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байгаа бөгөөд Чингэлтэй дүүргийн Улсын тэргүүний 33 дугаар цэцэрлэгт **124** сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж ажилтнуудын 2-5 насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлж байна.



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА

2019 компанийн цаг үеийн асуудлаар **21** видео нэвтрүүлэг бэлтгэн телевиз, сайтын шууд эфирээр давхардсан тоогоор **950** гаруй удаа цацагдсан байна. **745** мэдээ, сурвалжилга, зар, ярилцлага, хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагаас бэлтгэсэн **201** мэдээ, сурвалжилга, нийтлэл нийтдээ давхардсан тоогоор **13400** гаруй удаа сонин, сайтад нийтлэгджээ. Дотоод үйл ажиллагаанд зориулсан **14**, олон нийтэд үзэсгэлэн яармагт зориулсан **50** постер, хулдаасан хэвлэл бэлтгэсэн байна.

Компанийн албан ёсны вебсайт, Facebook, Twitter хуудас, Youtube сувгийг хөтлөн явуулж, "Эерэг дүр", "Сайн мэдээний уурхай" зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Компанийн худалдан авах үйл ажиллагааг нээлттэй ил тод байлгах хүрээнд 2019 онд нийт 138 тендерийн урилгыг Зууны мэдээ, Үндэсний шуудан, Өнөөдөр, Өдрийн сонин, UB post сонинд хэвлүүлж, нүүрс борлуулалттай холбоотой нээлттэй сонгон шалгаруулалтыг компанийн ett.mn сайтад тогтмол байршууллаа.

ЭЕРЭГ ДҮР ХӨТӨЛБӨР








САЙН МЭДЭЭНИЙ УУРХАЙ







1072 ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ 1800-1072

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор "Эрдэнэс-Тавантолгой" ХК-аас санаачлан "Хуримтлалтай Хувьцаатай иргэн" аяныг **21** аймаг, **330** суманд амжилттай зохион байгуулж 604 удаагийн уулзалт, сургалтаар **40,864** иргэнийг хамруулсан байна. Мөн төрийн албан хаагчдын **301** удаагийн сургалтыг зохион байгуулж **6406** албан хаагчийг хамруулж, **33130** иргэнээс дэлгэрэнгүй судалгаа авсан ба нийт **15000** гаруй иргэний хувьцааны анхан шатны баримтыг цахимжуулсан байна.

"1072 хувьцаа мэдээллийн төв" 2019 онд тогтмол зохион байгуулдаг сургалтаа төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуй нэгж, боловсролын байгууллагын хүсэлтээр **746** удаа зохион байгуулж нийтдээ **28402** иргэнийг хөрөнгийн зах зээлийн хамруулсны зэрэгцээ 1800-1072 лавлах утсаар **49,512**, албан ёсны фейсбүүк хуудсаар давхардсан тоогоор **1,841,718** иргэн уг төвтэй холбогдож, зохих мэдээллийг авсан байна.

ХУРИМТЛАЛТАЙ ХУВЬЦААТАЙ ИРГЭН













ERDENES-TT
НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
ХУВЬЦААНЫ ТОО
X
90 ТӨГРӨГ
=
НОГДОЛ АШИГ
1800-1072
www.ett.mn

ИРГЭН ТА ХЭДЭН ТӨГРӨГИЙН НОГДОЛ АШИГ АВАХ ВЭ

ERDENES-TT
НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
1072 ХУВЬЦААТАЙ
96480₮
1'080'592 ИРГЭН
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тогтоолоор иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, Монгол Улсын иргэн бүрт 536 ш хувьцаа эзэмшүүлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 116 дугаар тогтоолоор 536 ш хувьцаа нэмж олгосон.

ERDENES-TT
НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
1063 ХУВЬЦААТАЙ
95670₮
56'346 ИРГЭН
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2011 онд Эрүүл мэндийн даатгал хэлбэрээр 8040 төгрөгийн хишиг хувь хүртсэн бол 1063 хувьцаа эзэмшинэ.

ERDENES-TT
НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
964 ХУВЬЦААТАЙ
86760₮
34'491 ИРГЭН
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 100,764 төгрөг авсан бол 964 хувьцаа эзэмшинэ.

ERDENES-TT
НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
955 ХУВЬЦААТАЙ
85950₮
9'393 ИРГЭН
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2011 онд Эрүүл мэндийн даатгал хэлбэрээр 8040 төгрөгийн хишиг хувь хүртсэн, Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 100,764 төгрөг авсан бол 955 хувьцаа эзэмшинэ.

ERDENES-TT
НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
857 ХУВЬЦААТАЙ
77130₮
131'256 ИРГЭН
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 200,595 төгрөг авсан бол 857 хувьцаа эзэмшинэ.

ERDENES-TT
НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
848 ХУВЬЦААТАЙ
76320₮
41'359 ИРГЭН
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2011 онд Эрүүл мэндийн даатгал хэлбэрээр 8040 төгрөгийн хишиг хувь хүртсэн, 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 200,595 төгрөг авсан бол 848 хувьцаа эзэмшинэ.

ERDENES-TT
НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
750 ХУВЬЦААТАЙ
67500₮
667'898 ИРГЭН
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 300,426 төгрөг авсан бол 750 хувьцаа эзэмшинэ.

ERDENES-TT
НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
741 ХУВЬЦААТАЙ
66690₮
334'519 ИРГЭН
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2011 онд Эрүүл мэндийн даатгал хэлбэрээр 8040 төгрөгийн хишиг хувь хүртсэн, 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 300,426 төгрөг авсан бол 741 хувьцаа эзэмшинэ.

ERDENES-TT
НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
544 ХУВЬЦААТАЙ
48960₮
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2011-2012 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр 491,960 төгрөгийн хишиг, хувь хүртсэн бол 544 хувьцаа эзэмшинэ.

НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
536 ХУВЬЦААТАЙ
48240₮
28'160 ИРГЭН
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2010-2011 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр 500,000 төгрөгийн хишиг, хувь хүртсэн бол 536 хувьцаа эзэмшинэ.

НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
419 ХУВЬЦААТАЙ
37710₮
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2011 онд Эрүүл мэндийн даатгал хэлбэрээр 8040 төгрөгийн хишиг хувь хүртсэн, 2010-2011 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр 500,000 төгрөгийн хишиг, хувь хүртсэн, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 100,764 төгрөг авсан бол 419 хувьцаа эзэмшинэ.

НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
222 ХУВЬЦААТАЙ
19980₮
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2011-2012 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр 491,960 төгрөгийн хишиг, хувь хүртсэн, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 300,426 төгрөг авсан бол 222 хувьцаа эзэмшинэ.

НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
527 ХУВЬЦААТАЙ
47430₮
10'844 ИРГЭН
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2011 онд Эрүүл мэндийн даатгал хэлбэрээр 8040 төгрөгийн хишиг хувь хүртсэн, 2010-2011 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр 500,000 төгрөгийн хишиг, хувь хүртсэн бол 527 хувьцаа эзэмшинэ.

НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
329 ХУВЬЦААТАЙ
29610₮
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2011-2012 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр 491,960 төгрөгийн хишиг, хувь хүртсэн, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 100,764 төгрөг авсан бол 329 хувьцаа эзэмшинэ.

НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
214 ХУВЬЦААТАЙ
19260₮
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2010-2011 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр 500,000 төгрөгийн хишиг, хувь хүртсэн, Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 300,426 төгрөг авсан бол 214 хувьцаа эзэмшинэ.

НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
436 ХУВЬЦААТАЙ
39240₮
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2011-2012 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр 491,960 төгрөгийн хишиг, хувь хүртсэн, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 100,764 төгрөг авсан бол 436 хувьцаа эзэмшинэ.

НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
312 ХУВЬЦААТАЙ
28080₮
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2011 онд Эрүүл мэндийн даатгал хэлбэрээр 8040 төгрөгийн хишиг хувь хүртсэн, 2010-2011 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр 500,000 төгрөгийн хишиг, хувь хүртсэн, Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 334 дүгээр тогтоолын дагуу "Сайн хувьцаа хөтөлбөр"-өөр 200,595 төгрөг авсан бол 312 хувьцаа эзэмшинэ.

НЭГЖ ХУВЬЦААНД 90₮
8 ХУВЬЦААТАЙ
720₮
1800-1072
www.ett.mn

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 116 дугаар тогтоолын дагуу 2010-2011, 2011-2012 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр 991,960 төгрөгийн хишиг, хувь хүртсэн бол 8 хувьцаа эзэмшинэ.

ТАВАНТОЛГОЙН УУРХАЙН ХӨГЖИЛ

АВТО КОНВЕЙЕРИЙН СИСТЕМ НЭВТРҮҮЛНЭ

Компанийн зүгээс хөрс тээвэрт бутлуур, гадаргуугийн конвейер болон овоолго үүсгэгчийн иж бүрдэл систем ашиглах талаар судалж, Цанхийн уурхайд нэвтрүүлэх санал боловсруулах ажлын хэсгийг байгуулж холбогдох ажлуудыг хийж удирдлагад танилцуулан тус төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад шаардлагатай ажлын даалгавар боловсруулж байна.



ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ҮҮСЧ БОЛОХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР

- Олборлолтын өөрийн өртөг 30-40% буурч, уурхайн хүчин чадал, хөдөлмөрийн бүтээмж 1.5-2 дахин нэмэгдэнэ
- Авто тээврийн зай бага болсноор гүйлт, шатахуун, технологийн зогсолт багасах, засвар үйлчилгээний зардал багасах болон энерги зарцуулалт 14-16 хувиар буурах зэрэг талтай
- Автомашины тоо цөөрч бохирдол багасч, эргономик, экологийн сөрөг нөлөө багасах мөн программын хяналтад хамрагдаж автомат удирдлагын систем ашиглах боломж бүрдэнэ
- Дэвшилтэт технологи нэвтрүүлсэнээр ордын үнэ цэнэ өсөн, ур чадвар бухийн мэргэжлийн үндэсний инженерүүд бэлтгэгдэнэ.



КОМПАНИ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖТЭЙ БОЛНО

"Эрдэнэс-Тавантолгой" ХК уул уурхайн тоног төхөөрөмжтэй болох зорилгоор 2020 онд 124.7 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөөд байна.

АЖИЛЧДЫН ХОТХОН, УУРХАЙН ОФФИСЫГ ШИНЭЧИЛНЭ

2020 онд Цанхи хотхоныг шинэчлэх ажилд 3.8 тэрбум төгрөг, уурхайн оффисын шинэ барилгын бүтээн байгуулалтад 8.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төсөвлөн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна.



Хотхоны зураг төсөл



Уурхайн захиргаа

ЭРДЭНЭСИЙН ХОТ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын иргэд, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ажилчид, туслан гүйцэтгэгч компанийн ажилчид, нүүрс тээврийн жолооч нар, тэдний гэр бүл амьдрах 50-100 мянган хүн амтай **"ЭРДЭНЭСИЙН ХОТ"**-ыг байгуулах зорилт тавин ажиллаж байна.

УУРХАЙН ТООСЖИЛТЫГ БУУРУУЛНА

Компанийн зүгээс тоосжилтыг бууруулах зорилгоор "Ногоон хөгжил" төслийг эхлүүлэн 60.000 мод суулгац говийн хөрсөнд тариад байна. Цаашид Канад, Америкийн уул уурхайн компаниуд ашигладаг, байгаль орчинд ээлтэй нягтаршуулах бодисыг ашиглан тоосжилтыг 70 хүртэлх хувиар бууруулах боломжтой.



НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР



НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР

Хүчин чадал: **30 сая тонн/жилд**
CAPEX: **$600 сая**
OPEX: **$5.5 тонн**
Ашиглалтад орох: **2021-2024**

Төслийн гол зорилго нь ашиглалтын зардал багатай, дэвшилтэт техник, технологи бүхий нүүрс баяжуулах үйлдвэр байгуулан Тавантолгой ордын баяжигдах болон коксжих шинж чанар султай нүүрсийг, сайн чанарын нүүрстэй хольж баяжуулах замаар уурхайн ашиглалтын жилийг уртасгах, олон улсын шаардлагыг хангах нэмүү өртөг шингэсэн баяжмал бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм.

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хөгжлийн чиг хандлага, техник, технологийн бодлого, хүний нөөц, үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийг богино, дунд хугацаанд тодорхойлж, компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулсан компанийн 2017-2020 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөө, мөн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ-/өөс баталсан 2019 оны хөрөнгө оруулалтын төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн уурхайн тогтвортой хөгжил, өнөөгийн эдийн засгийн байдал, уул-геологийн ирээдүйн нөхцөл зэрэг хүчин зүйлүүдтэй уялдуулан нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ, техникийн зураг төслийг боловсруулж байна.

ХИЙГДЭЖ БУЙ АЖЛУУД

1. Тавантолгойн ордын нүүрсийг баяжуулах замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэн, бүтээгдэхүүний зах зээлийн үнийг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад болон дотоодын аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах судалгаа хийн, гэрээ хэлэлцээр хийх санал боловсруулах ажлууд хийгдэж байна.
2. Компанийн 2019 оны хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдсан "Нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ, FEED боловсруулах" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

КОКСЖИХ БОЛОН ДАГАЛДАХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРИЙГ БИЙ БОЛГОХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ

Төсөл нь 2 сая тонн дулааныг сэргээх замаар коксжуулах болон хаягдал дулааны эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагааг хамарна. Ажилчдын эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлага, Монгол орны газарзүйн онцлог, цаг уурын шинж чанар, үйлдвэрлэлийн хөгжлийн статусыг харгалзан үзэж Монгол Улсын дотоодын коксжих нүүрсийг ашиглан өндөр чанарын кокс үйлдвэрлэхийн тулд дэлхийд тэргүүлэгч БНХАУ-ын CHS бүрэн эрчим хүчийг сэргээх, байгаль орчинд ээлтэй коксжуулах технологийг нэвтрүүлнэ.

Төслийн ерөнхий төлөвлөгөө нь жилдээ 2 сая тонн кокс үйлдвэрлэхээс гадна 50МВт-ын уурын турбин үүсгэгч 4 багцыг хоёр үе шаттайгаар хийх ба эхний шатанд нүүрс бэлтгэх болон коксын гарцыг хянах төхөөрөмж нь 2 сая тонны хүчин чадалтай, кокс үйлдвэрлэх хүчин чадал 1 сая тонн , 50МВт-ын уурын турбин генераторын 2 багцтай цахилгаан үүсгүүртэй байна. Барилгын бүтээн байгуулалтын хугацааг 2 жилээр төлөвлөж байгаа хэдий ч нөхцөл байдлын дагуу өөрчлөгдөж болно.

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, ҮР ДАГАВАР

- Монгол Улсын эдийн засгийг нүүрсний нөөцөд тулгуурлан хөгжүүлэхийн тулд коксжих, эрчим хүч үйлдвэрлэх, химийн бодис, ган, барилгын материал, орчин үеийн логистик зэрэг аж үйлдвэрийн паркийг төлөвлөж барих нь зүйтэй.
- Монгол Улсын үйлдвэрлэлийн систем, туслах салбарыг хөгжүүлэх, сайжруулах шаардлагатай.
- Орос, Япон, Зүүн Европ дахь коксын байгууламжууд нь хуучирч муудаж байгаа ба энэ нь байнгын коксын нийлүүлэлтийг хангах боломжгүй юм.
- Хятад болон хөгжингүй орнуудад байгаль орчныг хамгаалах шаардлагууд илүү хатуу болж, коксын үйлдвэрлэл аажмаар багасаж, үйлдвэрлэлийн өртөг илүү өндөр болж байна. Тиймээс Монгол Улс олон улсын коксын зах зээл дэх нийлүүлэлтээ ихэсгэх асар их боломж байна.
- Монгол Улс коксжих нүүрсний арвин нөөцтэй бөгөөд өндөр чанартай кокс үйлдвэрлэн Япон, Европ, АНУ, Энэтхэг, Хятадын зах зээлд нийлүүлэх боломжтой.

ЗАГИЙН УСНЫ ХООЛОЙГ АШИГЛАХ АЖЛЫН ЯВЦ

"Эрдэнэс-Тавантолгой" хувьцаат компани уурхайн дэд бүтцийн усан хангамжийн эх үүсвэрийг Загийн усны хоолойгоос татаж авах бололцоог бүрдүүлэхээр "Монгол Ус" ТӨҮГ-тай "Санамж бичиг" байгуулсан.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах "Загийн усны хоолой"-н гүний усны ордоос Таван толгой нүүрсний уурхай хүртэл ус дамжуулах шугам хоолойн Техник эдийн засгийн үндэслэлийг 2019 онд боловсруулан баталгаажуулсан. Ус хангамжийн төсөл нь Загийн усны хоолойн хэсэгт нийт 14 ашиглалтын цооног гаргаж, усыг салбар шугам хоолойгоор цуглуулан нэгтгэж өргөлтийн насос станцуудын тусламжтайгаар далд шугам хоолойгоор шахаж уурхайн ойролцоо байрлах баяжуулах үйлдвэр болон бусад барилга байгууламж, хэрэглэгчид рүү хүргэгдэнэ.


Тавантолгой уурхайгаас 70-аад км зайтай энэхүү гүний усны орд нь 63,65 л/с усны нөөцтэй бөгөөд Эрдэнэс-Тавантолгой ХК нь ус хангамжийн шугам хоолойн барилга байгууламжийн нарийвчилсан зураг төслийг боловсруулахаар гүйцэтгэгч компанитай хамтран ажиллаж байна.

ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД **308.9 ТЭРБУМ** ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙВ

ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМ

Гол замын урт: **238.5 км**
Хүчин чадал: **30 сая тонн/жилд**
Тариф: **$0.033 тонн/км (нийт ~$8 тонн)**
Хөрөнгө оруулалт: **$1.07 тэрбум**

66 % ЭТТ ХК
34 % МТЗ ТӨХК



АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

- Засгийн газраас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдөр 304 дүгээр тогтоолыг баталж, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 66 хувийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК, 34 хувийг "Монголын төмөр зам" ТӨХК тус тус эзэмших, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д тус тус даалгасан.
- "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/438 дугаар тушаалаар Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Хамтарсан ажлын хэсгийг байгуулж, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хувьцааны 66 хувийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК, 34 хувийг "Монголын төмөр зам" ТӨХК тус тус эзэмших, санхүүжүүлэхтэй холбоотой баримт бичгийн төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэсэн.
- "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн хурлаас "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хувьцааны 66 хувийг эзэмших, гэрээ хэлцэл байгуулахыг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн 31 дүгээр тогтоолыг гаргасан.
- "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн дүрмийн төсөл болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хэлэлцэж, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийг төлөөлөх этгээдийг томилох, 15 тэрбум төгрөгийн санхүүжилт олгох тухай 36 дугаар тогтоолыг гаргасан;
- 2019 оны 08 дугаар сарын 16-нд "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж, компанийн дүрэм болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хэлэлцэж баталсан.
- 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хувьцаа эзэмшигчид болох "Эрдэнэс-Тавантолгой" ХК болон "Монголын Төмөр Зам" ТӨХК хамтран "Хувьцаа эзэмшигчдийн гэрээ"-г байгуулж хувьцаа эзэмшлийн асуудлыг баталгаажуулсан. "Хувьцаа эзэмшигчдийн гэрээ"-ний дагуу "Монголын төмөр зам" ТӨХК өмнө зарцуулсан хөрөнгийг баталгаажсан дүнгээр шилжүүлсний үндсэн дээр 34 хувийг эзэмших бол "Эрдэнэс-Тавантолгой" ХК 66 хувьд ногдох дүнг санхүүжүүлэх юм.
- "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хурлаас "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээнд заасны дагуу нийт 110,000,000 ам.доллартой тэнцэх төгрөгийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д шилжүүлэхийг зөвшөөрсөн 47 дугаар тогтоолыг гаргасан.
- "Эрдэнэс-Тавантолгой" ХК нь төсөл хариуцсан компани, Төслийг санхүүжүүлэгч байгууллагуудтай "Санхүүжилтийн гэрээ" байгуулснаар төслийн хөрөнгө оруулалтын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ҮҮСЧ БОЛОХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг ашиглалтад оруулснаар манай улсын нийгэм, эдийн засагт дараах эерэг нөлөө үзүүлнэ гэж тооцож байгаа юм.

Үүнд:
- Төмөр зам ашиглалтад орсноор манай улсын нутаг дэвсгэрийн доторх тээврийн нийт өртгийг 15 сая ам.доллараас 6 сая ам.доллар хүртэл бууруулах бөгөөд нүүрсний экспортын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ;
- Авто тээврийн улмаас үүсэж буй малын бэлчээрийн сүйтгэл, хөрсний доройтол, орчны тоосжилт, дуу шуугиан болон агаарын бохирдлын асуудал багасна;
- Авто тээврийн осол бууруулж хөдөлгөөний аюулгүй байдал дээшилнэ;
- Тавантолгойн бүлэг ордын уурхайнуудын олборлолтын хэмжээг 1-2 дахин нэмэгдүүлэх боломжтой болно;
- Монгол Улсад жилд 10-20 сая ам.долларын татвар төлөхөөс гадна 25 жилийн хугацаанд нийт 1 тэрбум ам.долларын ногдол ашиг Засгийн газарт өгнө;
- Монгол Улсын төмөр замын суурь бүтцийн хэмжээ нэмэгдэнэ;
- 2,000 орчим ажлын байр бий болно.





ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД **357 ТЭРБУМ** ТӨГРӨГИЙН САНХҮҮЖҮҮЛЭЛТ ХИЙВ.

ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМ

Гол замын урт: **414.6 км**
Хүчин чадал: **15-30 сая тонн/жилд**
Тариф: **$0.035 тонн/км (нийт ~$15 тонн)**
Хөрөнгө оруулалт: **₮2.85 их наяд ("Эрдэнэс-Тавантолгой" ХК-иас санхүүжүүлэх ₮750 тэрбум)**

ТӨР ЗАСГИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭРҮҮД

1. Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоол гарч, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн, хүүгүй, 20 хүртэл жилийн хугацаатай 750.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг нэрлэсэн үнээр нь хаалттай хүрээнд худалдахаар гаргахыг "Монголын төмөр зам" ТӨХК-д, гаргасан үнэт цаасыг нэрлэсэн үнээр нь худалдан авахыг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д тус тус даалгасан.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 16-д заасны дагуу Монгол Улсын Сангийн яамнаас 2019 оны 8-3/2765 тоот албан бичгээр 7,500,000 (долоон сая таван зуун мянга)-н ширхэг үнэт цаас гаргах зөвшөөрлийг "Монголын төмөр зам" ТӨХК-д олгосон.

3. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2019.05.01-ний өдрийн 53 дугаар захирамжийн дагуу байгуулсан ажлын хэсгийн хуралдаанаас төмөр замын төслийн ажлыг эхлүүлэхэд шаардлагатай урьдчилгаа санхүүжилтийг яаралтай шийдвэрлэх чиглэлийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн удирдлагад өгсөн.

"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН ЗҮГЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

1. Засгийн газрын дээрх тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд "МТЗ" ТӨХК болон "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирлуудын шийдвэрээр "МТЗ" ТӨХК-иас гаргах үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх хамтарсан ажлын хэсгийг 2019.05.14-ны өдөр байгуулсан.

2. Төмөр замын төслийн эхний ээлжинд яаралтай хийгдэх ажлуудыг санхүүжүүлэх зорилгоор "МТЗ" ТӨХК болон "Эрдэнэс-Тавантолгой" ХК 2019.05.07-ний өдөр "Төслийн санхүүжилтийн урьдчилгаа төлбөр олгох гэрээ"-г байгуулж 156,370,276,277.00 төгрөгийг шилжүүлсний үр дүнд төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны 5 дугаар сарын 24-ны өдөр эхлүүлсэн.

4. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хурлаас Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын санхүүжилтэд зориулж "Монголын төмөр зам" ТӨХК-иас гаргаж баталгаажсан үнэт цаасыг нэрлэсэн үнээр нь 750 тэрбум төгрөгт багтаан үе шаттайгаар худалдан авах, үнэт цаасны төлбөрийг санхүүжүүлэх гэрээ хэлцэл хийж (их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл) ажиллахыг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн 27 дугаар тогтоолыг гаргасан.

5. Хамтарсан ажлын хэсэг удаа дараа хуралдсаны үр дүнд "МТЗ" ТӨХК болон "Эрдэнэс-Тавантолгой" ХК-иуд харилцан тохиролцож "Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ", "Хамтын ажиллагааны гэрээ"-г 2019 оны 10 дугаар сарын 24-ны өдөр байгуулсан.

6. Санхүүгийн зохицуулах хорооноос 2019.12.27-ны өдрийн 407 дугаар тогтоолоор тус үнэт цаасыг бүртгэсэн ба одоогоор үлдэгдэл санхүүжилтийг шилжүүлэх ажил хийгдэж байна.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ҮҮСЧ БОЛОХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг ашиглалтад оруулснаар манай улсын нийгэм, эдийн засагт дараах эерэг нөлөө үзүүлнэ гэж тооцож байгаа юм. Үүнд:
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор төмөр замаар дамжуулан нүүрс, зэсийн экспортыг дэмжиж, Хятадын нутаг, түүний далайн боомт, мөн гуравдагч орны зах зээл рүү тээвэрлэлт хийх боломж бүрдэж Монгол улсын уул уурхайн компаниуд хямд үнээр дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой болно.
- Тавантолгой, Оюутолгой ордын нүүрс, зэснээс гадна трассын дагуу орших Хармагтай, Цагаан суварга, Манлай, Хараат уул, Төхөм зэрэг томоохон орд газруудын түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх боломжтой.
- 2020-2040 онуудад жил бүр 235-331 сая ам.долларын тээвэрлэлтийн орлого, 84-180 сая ам долларын үйл ажиллагааны зардал, 60-85 сая ам.долларын татварын дараах цэвэр ашиг, 20-28 сая ам.долларын ААНОАТ төлдөг төмөр замын компани байгуулагдана.
- Төсөл 20 жилийн хугацаанд нийт 5.6 тэрбум ам.долларын орлого олж, 2.6 тэрбум ам.долларын зардал гаргаж, 2.2 тэрбум ам.долларын татварын өмнөх ашиг, 1.6 тэрбум ам.долларын татварын дараах цэвэр ашигтай ажиллана.
- Төсөл үйл ажиллагаагаа эхэлснээр 20 жилийн хугацаанд Монгол улсад 537 сая ам.долларын ААНОАТ төлнө.
- Монгол Улсын төмөр замын суурь бүтцийн хэмжээ нэмэгдэнэ;
- 2,000 орчим ажлын байр бий болно.





УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН БОХИРДЛЫГ **55 ХУВИАР** БУУРУУЛЛАА


2018 оны 12 дугаар сар


2019 оны 12 дугаар сар

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах тухай” хуралдааны шийдвэрийг үндэслэн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх чиг үүрэг бүхий “Таван толгой түлш” ХХК-г "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийг түшиглэн үүсгэн байгуулсан.

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн зүгээс “Тавантолгой түлш” ХХК-д дэмжлэг үзүүлэн ажиллаж 2019 онд 111.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг “Тавантолгой түлш” ХХК-д шилжүүлж сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулжээ. Үүний үр дүнд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 55 хувиар бууруулж чадсан байна.

“Таван толгой түлш” ХХК нь 2019 онд 4 үйлдвэр 12 шугамаар өдөрт 3200-3500 тонн шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг барьж байгуулсан. 2019 оны тайлант жилд 203, 400 тонн шахмал түлш үйлдвэрлэн агаарын чанарыг сайжруулах бүсэд байрлах гэр хорооллын айл өрх болон аж ахуйн нэгжүүдийг хангаж ажиллалаа.







ТӨСЛИЙН ҮР ДҮН

“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК

нийт хөрөнгө оруулалт


БАРИЛГА БАЙГУУЛАМЖ
/12,2 тэрбум төгрөг/


МАШИН МЕХАНИЗМ
/12,3 тэрбум төгрөг/


ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
/21,9 тэрбум төгрөг/


Ажлын байр

Хот доторх жолооч 12% 300

Нийт борлуулагч 15% 392

Савлагч 27% 708

Нийт уртын тээврийн жолооч 46% 1200

■ Нийт борлуулагч ■ Нийт уртын тээврийн жолооч ■ Савалгаа ■ Хот доторхи жолооч

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА


Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төлөөлөгчид 2019 онд уул уурхай, хөрөнгө оруулалтын чиглэлээр 11 олон улсын үзэсгэлэн, бага хурал, форумд оролцжээ.

Компанийн нүүрс олборлолтыг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй шинэ технологи уурхайд нэвтрүүлэх судалгааг хийх зорилгоор БНХАУ-ын нүүрс баяжуулах үйлдвэр, конвейрийн систем үйлдвэрлэгч компаниуд, хүнд даацын автомашины дугуй үйлдвэрлэгчидтэй уулзалт зохион байгуулж, туршлага солилцох арга хэмжээнүүдийг зохион байгуулав. Түүнчлэн уул уурхайн нөхөн сэргээлт хийсэн туршлага, ойн зурвас газруудтай танилцлаа.

Австрали, Канад, АНУ, ХБНГУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудын уул уурхайн компаниуд, лабортори, тоног төхөөрөмж үйлдвэрлэгчидтэй хамтран ажиллаж "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах тохиролцоонд хүрсэн.

Компанийн нүүрсний борлуулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр зорилгоор БНХАУ-ын "Chalco Trading Hong Kong., Limited" компани, ОХУ-ын "ДВМП" нээлттэй хувьцаат нийгэмлэг, "FESCO" компанийн удирдлагуудтай хамтарсан уулзалтуудыг зохион байгуулав.

АНУ, Канад, Япон, БНХАУ-д зохион байгуулагдсан хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтуудыг оролцож компанийн үйл ажиллагааг сурталчилан танилцууллаа.



Японд Тавантолгой ордын бүтээн байгуулалтын талаар танилцууллаа



PDAC-2019 чуулга уулзалтын үеэр



ISO Стандартын баталгаажуулалтын гэрчилгээг гардан авлаа.



АНУ-ын уул уурхайн компаниудтай туршлага солилцлоо.





Олон улсын мэргэжилтнүүдэд Тавантолгойн төсөл, уурхайн үйл ажиллагааны талаар танилцуулав.

ХАМТЫН АЖИЛЛАГАА



Монгол Улсын "ТОП-100" аж ахуй нэгжийг тэргүүлэв.



Монгол Улсын Засгийн газрын гишүүд уурхайн үйл ажиллагаатай танилцав.



Монгол Улсын Их сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.



БСШУС-ын яамтай хамтран ажиллаж эхэллээ..



"Их Говийн илч" ХХК-тай хамтран нүүрс баяжуулж эхэллээ.



Шилдэг менежменттэй компаниар шалгарав.



Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нээлттэй хаалганы өдөрлөг



Архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэгт амжилттай хамрагдлаа.



ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА



“Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компани Өмнөговь аймгийн Засаг дарга, Цогтцэций сумын Засаг дарга нартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу 51 арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Хамтын ажиллагааны хүрээнд дараах томоохон ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нэрэмжит “Цэцийн Эрдэнэс” математикийн олимпиадыг 2019 оны 05 дугаар сарын 04-ны өдөр Цогтцэций сумын Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулав. Олимпиадад VI-XII ангийн нийт 26-н бүлгийн 710 суралцагчид, математикийн 5-н багш хамрагдсан байна.



Өмнөговь аймгийн Цогтцэций суманд компанийн лого бүхий хог ангилан хаях зориулалт бүхий хогийн савыг олон нийтийн газар байршуулах ажлыг зохион байгуулав.



Цогтцэций сумын Т.Борын нэрэмжит ЕБС-ийн сургуульд "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн нэрэмжит “Технологийн жишиг кабинет” байгуулав.



Орон нутгийн төрийн байгууллагуудын техник, материаллаг баазыг нэмэгдүүлэх, албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор 3 ширхэг Уаз-Фургон маркийн автомашиныг Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Цогтцэций сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс мөн тус сумын Гал түймэр унтраах, аврах 44-р ангид тус тус хүлээлгэн өглөө. Түүнчлэн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хамт олны санаачилгаар цуглуулсан сэтгэлийн хандив болох 5.000.000 төгрөгийг Өмнөговь аймгийн Онцгой байдлын газарт гардуулах ажлыг 2019 оны 03 дугаар сард зохион байгуулав.



Ахмадын өдөр"-ийг тохиолдуулан Цогтцэций сумын харьяат 48 ахмадыг "Ар үр" сувиллын газарт эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулан, сувилалд амраав.




2019 онд Цагаан-Овоо болон Сийрст багийн нийт 5-н худгийн амыг сэргээн засварласан бөгөөд Цагаан-Овоо багийн Шангай худаг, Хээрийн булаг, Булгийн ус худаг, Сийрст багийн Гүн ус 1-р худаг, Гүн ус 2-р худгийг тус тус сэргээн засварласан байна.



Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын Хөгжил мэдээллийн ордны спорт заалны засварыг хийж 2019 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хүлээлгэн өгөв.



Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Мэдээгүйжүүлэлт, хагалгааны нэгдсэн тасгыг тохижуулах ажлыг компанийн зүгээс санаачлан хэрэгжүүллээ.



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 154 дүгээр тогтоолын дагуу Нийслэлийн өмчит "Улаанбаатар спорт менежмент" ХК байгуулагдсан бөгөөд уг компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу Усан спортын ордны бүтээн байгуулалтад 5 тэрбум төгрөгийн дэмжлэг туслалцааг үзүүлжээ.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьд 2019 он хамтын ажиллагааг бүх чиглэлд амжилттай хөгжүүлсэн жил боллоо. Энэ онд 8 байгууллагатай шинээр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан байна.

Тухайлбал Монголын уул уурхайн салбарын чадавхыг дээшлүүлэх, хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэхэд талууд харилцан мэдлэг, мэдээллээ солилцох зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай санамж бичиг байгуулан ажиллаж байна. Санамж бичгийн хүрээнд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 184 ажилтан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т туршлага судалсан бөгөөд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 16 ажилтан салбарын үйл ажиллагаатай танилцан туршлага судлав.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газартай санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байгаа бөгөөд Чингэлтэй дүүргийн Улсын тэргүүний 33 дугаар цэцэрлэгт 124 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, ажилтнуудын 2-5 насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлж байна.

Компанийн ажилтнуудыг БНСУ-д эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний зорилго бүхий аялал, сургалтад хамруулах зорилгоор БНСУ-ын аялал, жуулчлалын төрийн өмчит корпорацтай ЭТТ-2019/496 тоот санамж бичиг байгууллаа. Санамж бичгийн хүрээнд 21 ажилтанг эрүүл мэндийн аялалд хамруулжээ.





Түүнчлэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн, Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль зэрэг сургалт, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудтай уул уурхайн салбарын залуу эрдэмтэн судлаачдад дэмжлэг үзүүлэх, компанийн ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, компанийн үйл ажиллагаанд шинэ технологи, инноваци нэвтрүүлэх, геологи уул уурхайн чиглэлийн чадварлаг боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нэрэмжит “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр 2020”-ийг зарлаж, шалгарсан 90 оюутанд 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр МУИС-ын Хурлын танхимд батламж гардуулав.





Иргэн та “Эрдэнэс-ТаванТолгой” ХК-ийн аппликейшныг татаж хувьцааны тоо ширхэг, ногдол ашгийн хэмжээгээ шалгаарай.



Гар утасны аппликейшн



Веб сайт хувилбар



Таблет хувилбар



Яаж татаж авах вэ?



Appstore-оос татаж авах:

Хайлтын нэр: “Эрдэнэс-ТаванТолгой”



Веб сайт ашиглаж дансаа шалгах:

www.ett.mn



Playstore-оос татаж авах:

Хайлтын нэр: “Эрдэнэс-ТаванТолгой”



Лавлах утаас:

1800-1072 энгийн утасны тарифаар

WWW.ETT.MN

http://1072.ett.mn/mn/

ЯГ ОДОО ТАТАЖ АВ!

Play store



App store



УБ хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Жигжиджавын гудамж-8 Финанс төв

7505 5555
1800 1072

www.erdenestt.mn

info@erdenestt.mn